



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 ^{дд} он ^{дб}
сарын ¹⁷ өдөр

Дугаар 31-1/99

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224002031



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²² он 06 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар ХТ/1281

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товллох тухай

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлон өгөхийг хүсье.

Хавсралт 721 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ


000225006769

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлд:

“XIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022. 6. 02 № 1/8091

танай 2022.5.18 -ны № 1/2594 -т

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Б.МӨНХБААТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай /Шинэчилсэн найруулга/, Кадастрын тухай /Шинэчилсэн найруулга/, Газрын төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төслүүд, дагалдан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151602858

А5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.05.31 № 01/3769
танай 2022.05.16 -ны № 1/2397 -т
Зөвшөөрөл өгөх тухай

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
САЙД Б.МӨНХБААТАР
ТАНАА

Танай яамнаас боловсруулсан Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон эдгээрийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762002513

ГАЗРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Ерөнхий хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын “Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зорилт”-ын хүрээнд:

- “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж;

- “Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.” гэж;

- “Газрын кадастрын нэгдсэн ухаалаг систем байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.” гэж;

- “Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.” гэж;

- “Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхид тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.” гэж;

- “Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.7-д “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.” гэж, 3.7.1-д “Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын “Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 54 дүгээр тогтоолоор Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн Газрын тухай болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Дээрх ажлын хүрээнд тус яамнаас Газрын тухай ерөнхий хуулийн төслийн үзэл баримтлалын зарим асуудал: Иргэний хууль ба Газрын тухай хууль сэдвээр захиалгат бодлогын судалгааг 2018 оны доктор Н.Баярмаа, Газрын талаархи нийтийн эрх зүйн

зохицуулалт, бодлогод хийсэн дүн шинжилгээг 2018 онд хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид нараар тус тус хийлгэсэн.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа Оросын Холбооны Улс, Герман, Япон, Казакстан, Естоны хууль эрх зүйн орчныг судалсан түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг судалж, холбогдох зүйл заалтуудыг уялдуулах, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатай заалтуудыг хэлэлцэн боловсруулсан.

2. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Барилга, хот байгуулалтын сайдын тушаал /2020/143, 2020/232/-аар Ажлын хэсэг байгуулагдаж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Газрын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, зардлын тооцоог хийж үзэл баримтлалыг 2021 оны 5 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдөр /Газрын харилцааны ажилтны өдөр/-өөр Газрын багц хуулийн төслийн хэлэлцүүлгийг холбогдох яамд, агентлагын төлөөлөл болон холбогдох төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан, 2020 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд, аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын төлөөллүүд нийт 200 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч хуулийн төсөлд тусгасан. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан гарах хуулиудын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдсэн холбогдох судалгааны төслүүдэд 2021 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн 01/1416 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудаас санал авахаар хүргүүлж, ирүүлсэн саналыг Ажлын хэсгийн хүрээнд хэлэлцэн хуулийн төсөлд тусгасан.

Газрын багц хуулийн төслийг www.mcud.gov.mn сайтад 2021 оны 04 дүгээр сарын 16-наас 2021 оны 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд байршуулж, иргэд олон нийтээс 84 санал ирүүлсэнтэй ажлын хэсэг нэг бүрчлэн танилцаж хуулийн төсөлд тусгасан.

2021 оны 04 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Батлан хамгаалах яам, Эрчим хүчний яам болон бүх аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын газрын даамлууд болон нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргүүдийн газрын албадын мэргэжилтэн, салбарын төрийн бус байгууллагуудад цахимаар хэлэлцүүлгийг зохион байгуулж Газрын багц хуулийн төслийн танилцуулгыг хийж, саналын авч хуулийн төсөлд тусгасан.

2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд, ажлын хэсгийн гишүүдийн хамт Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн нарийн бичгийн дарга

Б.Баасандорж болон албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж хуулийн төслийн танилцуулгыг хийж хуулийн төслийн концепцийг танилцуулж санал бодлоо солилцож зарчмын асуудлууд дээр тохиролцсон.

2021 оны 08 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яамдтай дахин уулзалт зохион байгуулж тэдгээр яамдаас ирүүлсэн санал хуулийн төсөлд хэрхэн туссан болон зарим тайлбар тодруулгыг авч ажилласан болно.

2021 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Мэдээлэл, харилцаа, холбооны 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн үеэр Мэдээлэл, харилцаа, холбооны опериаторуудын холбоодын төлөөлтэй уулзалт зохион байгуулж Газрын багц хуулийн төслийн танилцуулгыг хийж саналыг авч хуулийн төсөлд тусгасан. Мөн 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргүүдийн газрын албаны албан хаагчдын дунд хэлэлцүүлгийг зохион байгуулж дахин санал авсан. 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Хүний эрх хөгжлийн төв төрийн бус байгууллагуудын форумын гишүүн 22 байгууллагын төлөөлөлд хуулийн төслийг танилцуулж, саналыг авсан.

Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг Ажлын хэсэг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тус тус тусгасан бөгөөд хуулиудын шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хувилбарыг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан.

Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн хурлаар 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хэлэлцүүлсэн. Тус хэлэлцүүлгээс гарсан холбогдох саналуудыг мөн Ажлын хэсгийн хүрээнд шийдвэрлэсэн. 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга холбогдох албан тушаалтантай уулзалт зохион байгуулж хуулийн төслийг танилцуулж холбогдох саналыг авч тусгасан.

2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр "Эрх зүйн шинэтгэлт ба хүний эрх; Газрын эрх зүйн анхаарах асуудал" цуврал хэлэлцүүлгийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн танхимд Газрын багц хуулийн төслийг танилцуулсан бөгөөд УИХ-ын тамгын газар, холбогдох яамд, төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөлд оролцсон.

Ажлын хэсгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 17, 18 дугаар зүйлд заасан, тус хуулийн 12.1.3, 12.1.4-т заасан аргачлал /Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гурав, дөрөвдүгээр хавсралт/-ын дагуу Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох ажлыг зохион байгуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахад шаардагдах эдгээр баримт бичгүүдийг боловсруулан бүрдлийг хангасан.

Газрын ерөхий хуулийн төсөлтэй холбогдуулан дагалдан гарах 38 хуулийн төслийг боловсруулсан болно.

3. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтууд.

Газрын тухай хууль нь 2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр нийт 7 бүлэг, 64 зүйлтэйгээр батлагдсан. Хууль батлагдсанаас хойш бусад хуульд өөрчлөлт орсны улмаас Газрын тухай хуульд нийтдээ 32 удаа хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад шинэ тутам үүсэж байгаа газартай холбоотой олон талт харилцааг 2002 онд батлагдсан Газрын тухай хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж, тус хуулийг боловсронгуй болгох, өөрчлөх замаар шийдвэрлэвэл зохих олон асуудал үүссэн.

Хуулийн төслийн зорилтоос эхлээд өнөөдөр энэхүү салбарт хэрэгцээ нь үүсэж, шаардагдаж байгаа дараах зохицуулалтуудыг хуулийн төсөлд шинэчлэн болон шинээр тусган хуульчилсан. Үүнд:

Газрын тухай хуулийн давхардал, хийдэл зөрчлийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгааны тайланд “Тус хуульд 7 давхардал, 29 зөрчил, 25 хийдэл байна” гэжээ. Мөн газартай холбоотой бусад хуулиуд болох Хот байгуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай зэрэг хуулиудад хийсэн давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар мөн тодорхой тоо баримтууд дурдагдаж байна.

Дээрх голлох хууль тогтоомжийг 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулиар бэхжүүлсэн газрын харилцааны шинэтгэлийн үр дүнд баталсан хэдий ч өнөөдөр нийт 60 гаруй хуульд газрын талаарх зохицуулалтыг нэмэлтээр бий болгосон байна. Эдгээр салбар хуулиуд зэрэгцэн үйлчилж, газрын харилцааг зохицуулж байгаа нь хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, хэрэглэгч болох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд ойлгомжгүй эрх зүйн үр дагаврыг үүсгэжээ. Иймд Газрын тухай хууль тогтоомжийн нэгдмэл системчлэлийн асуудлыг энэ хуулиар шийдвэрлэх нь зүйтэй байна.

Үүний зэрэгцээ 200 орчим захиргааны хэм хэмжээний актаар газрын харилцааг зохицуулж байгаа нь хуулиар зохицуулах ёстой асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа, хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлан мөрдүүлж байгаа зэрэг зөрчлийг үүсгэж байна.

Салбар хуулиудаар газрын талаарх бүрэн эрхийг салгаж зохицуулснаас тухайлбал 6 яаманд газрын бүртгэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох хэм хэмжээг бий болгожээ. Энэ нь Газрын тухай хуульд заасан “Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх” үндсэн зарчмыг алдагдуулж, үүнээс бий болох сөрөг үр дагаврыг иргэд, хуулийн этгээд үүрэхэд хүргэж, нийгэм, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах эх үндэс болж байна. Газрын харилцааг зохицуулж буй хуулийн тоо олон, нэгдмэл зарчимд суурилж чадаагүй нь газрын харилцаатай холбоотой яамдын чиг үүргийн давхцлаас тод харагдаж байна.

Иймд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийн асуудлыг нарийн зааглан ялгаж, нарийвчлан тодорхойлсон.

Улсын Их Хурал нь төрөөс газрын талаар баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлдог учраас Засгийн газрын саналыг үндэслэн улсын хэмжээнд газрын харилцааны салбарт хийгдсэн ажлын явц, үр дүнг болон Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлдэг байх, шаардлагатай тохиолдолд хэсгээр буюу бүхэлд нь Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд оруулж хэлэлцүүлж байхаар хуулийн төсөлд тусгаж, газрын талаарх төрийн бодлого, хууль эрх зүйн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтыг тодорхойлох, үүнд шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэхээр тусгав.

Газрын тухай хуульд газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан ангилсан газрын нэгдмэл сангийн зарим үндсэн болон дэд ангиллыг Ойн тухай, Усны тухай хууль, олон улсын ангилал, холбогдох хууль тогтоомжтой уялдуулан дахин нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Газрын тухай хуульд газар зохион байгуулалт, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан боловч тэдгээрийн агуулга, уялдаа холбоо, зарчим, үйл ажиллагааны дараалал, хэрэгжих арга зүй, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан. Түүнчлэн, газар зохион байгуулалтын төлөвлөлтүүдийн мэдээллийн сан, түүнд тавигдах стандарт шаардлага тодорхойгүй байгаа мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдахгүй байгаа зэргээс газар зохион байгуулалтын төлөвлөлтийг салбар бүр тус тусдаа хийх, тэдгээр нь хоорондоо уялдаагүй улмаар иргэн, хуулийн этгээдэд газар давхардуулан олгох, төлөвлөлтүүд нь ёс төдий, хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийн төрлүүд, тэдгээр бүсчлэл дэх газар ашиглалтын зориулалт бүрд тавигдах дэглэм, зөвшөөрөгдөх газар ашиглалтын төрөл, эрхийн хэлбэрийг тодорхой болгох /ойн сан бүхий газарт зуслан гэх мэт суурьшил үүсэх, үндсэн ангиллын зориулалт, хэрэгцээнд нийцэхгүй дэд ангиллыг бий болгох /бичил уурхай г.м/ газрын төлөв байдал, чанарыг доройтуулах нөхцөлийг тодорхойлж хариуцлагыг хуульчилж өгөв.

Газар зохион байгуулалтын төлөвлөлт хийхдээ газрын талаарх иж бүрэн суурь судалгаа, газар ашиглалтын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээ, нийгэм, эдийн засгийн мэдээлэлтэй төдийлөн холбон тооцож үзэхгүй байгаа, газар ашиглалтыг үндэслэл муутай төлөвлөснөөр төлөвлөлтүүд нь ёс төдий, хэрэгжихгүй байх нөхцөлд хүрч байна.

Иймд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг цогц байдлаар тодорхойлж, төлөвлөлтийн дэс дараалсан үйл ажиллагааг тодорхой болгон хуульчлах, төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, тодотгол хийх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж өгөв.

Газар эзэмших эрхийг эд хөрөнгийн бие даасан эрх байхаар тодорхойлсон нь эдийн засгийн агуулгагүй, бие даан хэрэгжүүлэх боломжгүй байгаагийн зэрэгцээ практикт газар эзэмших эрх нь газар өмчлөх эрхээс төдийлөн ялгарахгүй байгаа юм. Одоогийн эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогдсон газар өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн 3 эрхийн төрлийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуулийн суурь үзэл баримтлал болон олон улсад нийтлэг хэрэглэгдэж буй эд хөрөнгийн эрхийн зохицуулалттай нийцүүлэн томьёолох зайлшгүй шаардлагатай байгаа тул хуульд заасан эрхийн зохицуулалтыг өөрчилсөн.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулах хугацааг газар ашиглалтын зориулалтаас үл хамааран 15-60 хүртэл жил байхаар заасан. Энэ нь газрыг түр, богино хугацаагаар гэрээгээр ашиглах нөхцөлийг хаадаг тул газар ашиглуулах хугацааг газар ашиглалтын зориулалттай уялдуулан тусгах шаардлага гарсан.

Иргэний эрх зүйн эдийн баялгийн эрх зүйн үндсэн зарчим болох хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөндөө үлдэх зарчимд үл хамаарах тохиолдлуудыг туйлын тодорхой тусгах, үүний нэг нь шинээр баригдсан болон хувьчлагдсан нийтийн зориулалттай орон сууц эзэмшигчдийн газрын эрхийн асуудлыг “Кондоминиум” /дундын мэдлийн газрын эрх/ хэмээх эд хөрөнгийн эрх болохыг анхаарч зохицуулах шаардлага нэгэнт тулгарсан байгааг харж хуулийн төсөлд нарийвчилсан зохицуулалтыг тусгалаа.

Газрын эрхийн бүртгэлийн зорилго нь газар өмчлөгч төр, иргэн, бусад иргэд, хуулийн этгээдэд газар олгох, шилжүүлэх замаар эдийн баялгийн эрх үүсгэснийг бүртгэж эрхийн хүчин төгөлдөр байдлыг хангах, газар төлөвлөлт, зохион байгуулалтад шаардлагатай мэдээллийн сан, бааз суурь бүрдүүлэхэд оршино. Дэлхийн улс орнууд “нэг төр нэгдсэн нэг бүртгэл” буюу газрын нэгдсэн бүртгэлийн тогтолцоотой гэсэн зарчмаар ажилладаг бол Монгол Улсад газрын бүртгэлийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрын бүртгэл/, Ашигт малтмалын газар /уул уурхайн газар/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /тусгай хамгаалалттай газар/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /тариалан, бэлчээр/, Улсын бүртгэлийн ерөнхий газар /өмчлөх эрхийн бүртгэл/ зэрэг байгууллагууд зэрэгцэн эрхэлж байгаа нь чиг үүргийн давхардал болон зохиомол шат дамжлагыг бий болгохын зэрэгцээ газрын сан нэгдмэл байх зарчмыг алдагдуулж байна.

Иймд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад яамд, агентлагийн эрх, үүргийн асуудлыг нарийн зааглан ялгаж, нарийвчлан тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна. Ингэхдээ тухайн байгууллага, салбарын үндсэн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр зөвхөн газрын нөхцөл, нөөц, даац чадавхи, иргэн, улс орны хэрэгцээг харгалзсан төлөвлөлт, кадастрын бүртгэл мэдээлэл нэгдсэн байхаар хуульчлахад онцгой анхаарсан болно.

Газрын харилцааны асуудал Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын асуудал билээ. Энэ утгаараа нэгдмэл, тогтвортой бодлогоор зохицуулагдах шаардлага тавигддаг. Гэтэл одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуульд газрын харилцааны асуудал орон нутгийн удирдлага/нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага/-аас шууд хамааралтай байхаар хуульчлагдсан байгаа нь мэргэжлийн байх, нэгдсэн тогтолцоотой байх нөхцөлийг алдагдуулж байна.

Газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах зориулалт, тэдгээр зориулалт бүрд тавигдах шалгуур үзүүлэлт, төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгож хуульчлахын зэрэгцээ улс, орон нутгийн тусгай болон нийтийн хэрэгцээг үндэслэн нийгмийн зайлшгүй хэрэгцээнд газрыг чөлөөлөх, газар хамгаалах, нөхөн сэргээх, газрыг дүйцүүлэн хамгаалах болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхтэй холбоотой зарчмын тулгуур асуудлыг тусгасан.

Одоогийн мөрдөгдөж буй Газрын тухай хуульд гэр бүлийн хамтын хэрэгцээний болон төсөвт байгууллагад зайлшгүй эзэмшүүлэхээс бусад зориулалтаар олгох газрыг дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах зарчмаар эзэмшүүлэхээр хуульчилсан боловч ямар тохиолдолд дуудлага худалдаа, эсвэл төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар газар эзэмшүүлэхийг нарийвчлан зааж өгөөгүй тул энэ талаар нарийвчилсан тусгасан.

Газрын биржээр ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхой бус байгаа тул хуулийн энэхүү заалт өнөөг хүртэл хэрэгжихгүй байна. Иймд төрийн өмчийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох, газрын дуудлага худалдааг зохион байгуулах, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, Монгол Улсын иргэн өмчилсөн газраа дуудлага худалдаагаар арилжихад зуучлах, иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхийг дуудлага худалдаагаар арилжихад зуучлах зэрэг үйл ажиллагааг газрын биржээр дамжуулан явуулж байх, газрын биржийн үйл ажиллагааны дүрэм, ажиллах журмыг Засгийн газар баталдаг байх зохицуулалтыг шинээр тусгав.

Хот, тосгон, бусад суурины газрын нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтын зохицуулалт тодорхойгүйгээс үүдэн нийтийн эдэлбэрийн газрыг зөвшөөрөлгүй дур мэдэн эзэмших, ашиглах зөрчил даамжирч, улмаар эзэнгүйдэх асуудал гарч байгаа тул нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтын талаарх зүйл, заалтыг илүү нарийвчлан тусгаж, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт нэмсэн.

Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарт мониторинг хийж үнэлэлт дүгнэлт өгөх замаар доройтсон газрыг сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч хэрэгжүүлдэг байх тогтолцоог хуульчилсан.

Газрын зөрчил маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа цаг хугацаа авдаг тул иргэд залхдаг, шийдвэрлэх гэсээр байтал үл хөдлөх хөрөнгө баригдаж дуусдаг асуудал түгээмэл байна.

Иймд аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд хүн, хуулийн этгээдээс газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх, дундын мэдлийн газрын эрх, газрыг гэрээгээр ашиглуулах, газар чөлөөлөхтэй холбоотой гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус газрын маргаан таслах зөвлөлтэй байхаар хуулийн төсөлд тусгав.

Хориглосон, хязгаарласан заалтыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний тухай зүйл, заалт нэмж, газрын чанарыг доройтуулах, хохирол учруулах, нөхөн сэргээхгүй байгаа зэрэг зөрчилд хяналт шалгалт хийх эрхтэй этгээд, түүний бүрэн эрхийг тодорхой болгож, улмаар хөндлөнгийн мониторинг хийх боломжийг тусган, хяналт шалгалт болон мониторингийн үр дүнд хэрэглэх албадлага, хариуцлагыг тодорхойлон, үр дүнтэй байхаар

зохицуулах тухай зүйл, заалтыг илүү нарийвчлан тусгаж, шаардлагатай тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалт нэмсэн болно.

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 11 бүлэг 110 зүйлтэй боловсруулсан.

---o0o---



ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, “Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.” гэж, “Газрын кадастрын нэгдсэн ухаалаг систем байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.” гэж, “Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.” гэж, “Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.” гэж, “Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.7-д “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.” гэж, 3.7.1-д “Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”- ийн 106-д газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үндэсний хэмжээний стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, Засгийн газрын мэдлийн нөөц газар болон улсын тусгай хэрэгцээний газарт явуулах бодлого, зохицуулалтыг тодорхой болгох, газар олгох эрх бүхий этгээдийн эрх, үүргийг зааглаж, нарийвчлан тодорхойлсноор төлөвлөлтгүй, давхардуулж газар олгодог байдлыг зогсоох, төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн хэрхэн, ямар шалгуураар төлөвлөх, уг

төлөвлөгөөг боловсруулахад холбогдох байгууллагын оролцоог тодорхой болгох, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нөхөн сэргээх, мал болон бэлчээрийн зохистой харьцааг бий болгох, бэлчээрийг нийтээр, дундаа ашиглах газар, түүнд хамаарах эрх бүхий этгээдийн эрх, үүргийн талаарх зохицуулалтыг бий болгох зорилгоор Засгийн газраас Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын “Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 54 дүгээр тогтоолоор Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн Газрын тухай болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

2.1. Практик шаардлага

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад шинэ тутам үүсэж байгаа газартай холбоотой олон талт харилцааг 2002 онд батлагдсан Газрын тухай хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж, тус хуулийг боловсронгуй болгох, өөрчлөх замаар шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсэж байна. Тухайлбал:

1. Газрын тухай хуульд нийтдээ 30 удаа нэмэлт, өөрчлөлт орсон нь бусад хуульд өөрчлөлт орсны улмаас дагалдаж орсон байна.

Газрын тухай хуулийн давхардал, хийдэл зөрчлийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгааны тайланд дурдсанаар тус хуульд 7 давхардал, 29 зөрчил, 25 хийдэл байна. Мөн газартай холбоотой бусад хуулиуд болох Хот байгуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай зэрэг хуулиудад хийсэн давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар мөн тодорхой тоо баримтууд дурдагдаж байна.

Монгол Улсын нийт 60 гаруй хуульд газрын талаарх зохицуулалт, 200 орчим захиргааны хэм хэмжээний актаар мөн газрын харилцааг зохицуулж байгаа нь газрын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, хэрэглэгч болох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд ойлгомжгүй байдлыг үүсгэж, хуулиар зохицуулах шаардлагатай асуудлыг тусгайлан эрх олгоогүй актаар зохицуулж байна.

Ийнхүү салбарын хуулиудаар газрын талаарх бүрэн эрхийг салгаж зохицуулснаас тухайлбал, 6 байгууллагад газрын бүртгэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох зохицуулалтыг бий болгожээ. Энэ нь Газрын тухай хуульд заасан “Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх” үндсэн зарчмыг алдагдуулж, иргэд, хуулийн этгээдэд эрх ашигт сөргөөр нөлөөлж, нийгэм, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах эх үндэс болж байна. Газрын харилцааг зохицуулж буй хуулийн тоо олон, нэгдмэл зарчимд суурилж чадаагүй нь газрын харилцаатай холбоотой яамдын чиг үүргийн давхцлаас харагдаж байна.

Иймд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийн асуудлыг нарийн тодорхойлох, Газрын тухай хууль тогтоомжийн нэгдмэл байдал болон газартай холбогдох бусад хуулиудын уялдаа холбоог хангах нь зүйтэй байна.

2. Төр өөрийн өмчийн газрын ашиглалтын зориулалтыг харгалзан иргэний эрх зүйн оновчтой механизмаар иргэддээ ашиглуулах, газар төрийн хамгаалалт, ард түмний мэдэлд байх, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн үр ашгийг бий болгох, зөв хүртэх харилцааг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл

баримтлалын хүрээнд дахин авч үзэх, ингэхдээ тусгаар тогтнол, төрийн байгууламж, эдийн засгийн болон хот ба хөдөөгийн тэнцвэртэй хөгжил, байгаль орчныг хамгаалах, өмчлөх эрхийг хамгаалах, иргэддээ тэгш боломж олгох, баялгийн хуваарилалтын шударга ёсыг бий болгох, улмаар ядуурлыг бууруулан олон төрөлт эдийн засгийг буй болгох зорилгыг хангах нь чухал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ингэхдээ Иргэний хуулийн эдийн баялгийн эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчим, арга хэрэгслийг ашиглах, газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялгийг ард түмнийг төлөөлөн захиран зарцуулах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийн уялдаа холбоог сайжруулж, газар хамгаалах хяналтын тогтолцоог бий болгох, газрыг ашиглах зарчим, эрхийн төрөл, суурь хэм хэмжээг тогтоох, нэгдсэн бүртгэлээр өмчлөх эрх болон эд юмсын хязгаарлагдмал эрхийг хамгаалах зэрэг харилцааг нарийвчлан зохицуулах, зааг ялгааг тодорхойлох шаардлагатай байна.

3.Хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар төрийн өмчид буй газар нь “Төрийн нийтийн зориулалттай өмч” хэмээх ангилалд хамаардаг. Гэвч газар нь нийтийн өмчийн сонгодог ангиллаар зарим төрлийн нийтийн зориулалттай эд зүйлсээс ихээхэн ялгаатай. Иймд газрыг өмчлөлийн шинж байдал, зориулалтаас шалтгаалан бусад төрлийн нийтийн эд зүйлсээс ялгаатай авч үзсэн зохицуулалт нэн даруй хэрэгцээтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд газрыг төр, иргэн гэсэн хоёр субъект өмчлөх эрхтэй байхаар заасан. Төр өөрийн өмчийн газрыг Үндсэн хуульд заасны дагуу өөрийн орны иргэнд өмчлүүлэх асуудлыг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар, бусдад эзэмшүүлж, ашиглуулахтай холбоотой харилцааг Газрын тухай хуулиар зохицуулж ирсэн ч бусдад эзэмшүүлж, ашиглуулаагүй төрийн өмчид байгаа газрыг арчлах, хамгаалах, хариуцуулах асуудлыг орхигдуулсан байна.

Төрийн өмчийн газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага буюу Засаг даргын мэдэлд байж Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлэх, эзэмшүүлж, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж байна. Төрийн өмчийн газрыг төрийн нэрийн өмнөөс захиран зарцуулж байгаагийн хувьд тухайн шатны Засаг дарга нарт улсын тусгай хэрэгцээнд авсан газраас бусад ангиллын газрыг зохих эрх зүйн актын дагуу хүлээлгэн өгдөг, түүний төлөвлөлт, бүртгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьдаг байх, нийтийн эдэлбэрийн газар, төсөвт байгууллага, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн газрыг бүртгэх, эзэнжүүлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

4.Газрын тухай хуульд газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан ангилсан газрын нэгдмэл сангийн зарим үндсэн болон дэд ангиллыг Ойн тухай, Усны тухай хууль, олон улсын ангилал, холбогдох хууль тогтоомжтой уялдуулан дахин нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

5.Газрын тухай хуульд газар зохион байгуулалт, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан боловч тэдгээрийн агуулга, уялдаа холбоо, зарчим, үйл ажиллагааны дараалал, арга зүй, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хуульчилгүй орхигдуулсан. Түүнчлэн, газар зохион байгуулалтын төлөвлөлтүүдийн мэдээллийн сан, түүнд тавигдах стандарт шаардлага тодорхойгүй байгаа зэргээс газар зохион байгуулалтын төлөвлөлтийг салбар бүр тус тусдаа хийх, тэдгээр нь хоорондоо уялдаагүй улмаар иргэн, хуулийн этгээдэд газар давхардуулан олгох, төлөвлөлтүүд нь ёс төдий, хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөлт хийхдээ газрын талаарх иж бүрэн суурь судалгаа, газар ашиглалтын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээ, нийгэм, эдийн засгийн мэдээлэлтэй төдийлөн холбон тооцож үзэхгүй байгаа,

газар ашиглалтыг үндэслэл муутай төлөвлөснөөр төлөвлөлтүүд нь ёс төдий, хэрэгжихгүй байхад хүргэж байна.

Иймд газар зохион байгуулалтын төлөвлөгөө тус бүрийн агуулга, тэдгээрийн уялдаа холбоо, тавигдах шаардлагыг тодорхой болгохын зэрэгцээ төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих этгээдийн эрх, үүргийн талаар дэлгэрэнгүй тусгана.

Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулдаг байх нь зүйтэй бөгөөд ингэхдээ газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд Засаг дарга төлөвлөгөөнд газрын эрхийг ямар аргаар олгохоо нарийвчлан тусгаж батлуулна. Уг батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг, газрын эрх олгох асуудлыг шийдвэрлэдэг болно. Дүүргийн газрын алба, сумын газрын даамал газрын эрх олгох шийдвэр гаргахгүй бөгөөд гэрээ хийж газрын эрхийг улсын бүртгэлийг хөтөлдөг байх зохицуулалтыг тусгана. Ингэснээр шат дамжлага багасаж, газрын улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байгууллагуудын хооронд уялдаа холбоо сайжирч албан тушаалтны хариуцлага өндөрсөх, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ.

6. Газар эзэмших эрхийг эд хөрөнгийн бие даасан эрх байхаар тодорхойлсон нь эдийн засгийн агуулгагүй, бие даан хэрэгжүүлэх боломжгүй байгаагийн зэрэгцээ практикт газар эзэмших эрх нь газар өмчлөх эрхээс төдийлөн ялгарахгүй байгаа юм.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар тодорхойлогдсон газар өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн эрхийн 3 төрлийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуулийн суурь үзэл баримтлал болон олон улсад нийтлэг хэрэглэгдэж буй үндсэн эд хөрөнгийн эрхийн зохицуулалттай нийцүүлэн томъёолох зайлшгүй шаардлагатай байгаа тул хуульд заасан эрхийн зохицуулалтыг өөрчлөх нь зүйтэй байна.

7. Иргэний эрх зүйн эдийн баялгийн эрх зүйн үндсэн зарчим болох хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөндөө үлдэх зарчимд үл хамаарах тохиолдлуудыг туйлын тодорхой тусгах, үүний нэг илэрхийлэл нь “Кондоминиум” эрх /үл хөдлөх хөрөнгийн доорх болон орчны газрыг үл хөдлөх хөрөнгө өмчлөгчид захиран зарцуулах эрх/ болохыг анхаарч зохицуулах шаардлага нэгэнт тулгарсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд орон сууц болон хэсгээр өмчлөх дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн доорх болон орчны газрын нэгж талбарын дугаарт үндэслэн бүртгэхээр тусгагдсан. Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, холбогдох зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

8. Газрын эрхийн бүртгэлийн зорилго нь газар өмчлөгч төр, иргэн, бусад иргэд, хуулийн этгээдэд газар олгох, шилжүүлэх замаар эдийн баялгийн эрх үүсгэснийг бүртгэж эрхийн хүчин төгөлдөр байдлыг хангах, газар төлөвлөлт, зохион байгуулалтад шаардлагатай мэдээллийн сан бүрдүүлэхэд оршино.

Дэлхийн улс орнууд “Нэг төр-нэгдсэн нэг бүртгэл” буюу “Газрын нэгдсэн бүртгэлийн тогтолцоо”-той байх зарчмаар ажилладаг бол Монгол Улсад газрын бүртгэлийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрын бүртгэл/, Ашигт малтмалын газар /уул уурхайн газар/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /тусгай хамгаалалттай газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар /өмчлөх эрхийн бүртгэл/ зэрэг байгууллагууд зэрэгцэн эрхэлж байгаа нь чиг үүргийн давхардал болон зохиомол шат дамжлагыг бий болгохын зэрэгцээ газрын сан нэгдмэл байх зарчмыг алдагдуулж байна.

Иймд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад яамд, агентлагийн эрх, үүргийн асуудлыг зааглан ялгаж, нарийвчлан тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна. Ингэхдээ тухайн байгууллага, салбарын үндсэн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр зөвхөн газрын нөхцөл, нөөц, даац чадавхи, иргэн, улс орны хэрэгцээг харгалзсан төлөвлөлт, кадастрын бүртгэл мэдээлэл нэгдсэн байхаар хуульчлахад онцгой анхаарах нь зүйтэй байна.

9.Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу газрын харилцааны асуудал Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын асуудал билээ. Энэ утгаараа нэгдмэл, тогтвортой бодлогоор зохицуулагдах шаардлага тавигддаг.

Гэтэл одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуульд газрын харилцааны асуудал орон нутгийн удирдлага /нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага/-аас шууд хамааралтай байхаар тусгагдсан нь мэргэжлийн байх, нэгдсэн тогтолцоотой байх нөхцөлийг алдагдуулж байна.

Иймд газрын харилцаанд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын болон газрын мэргэжлийн төрийн захиргааны, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг зааглан тодорхойлно.

10.Газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах зориулалт, тэдгээр зориулалт бүрд тавигдах шалгуур үзүүлэлт, төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгож хуульчлахын зэрэгцээ улс, орон нутгийн тусгай болон нийтийн хэрэгцээг үндэслэн нийгмийн зайлшгүй хэрэгцээнд газрыг чөлөөлөх, газар хамгаалах, нөхөн сэргээх, газрыг дүйцүүлэн хамгаалах болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхтэй холбоотой зарчмын тулгуур асуудлыг Газрын тухай хуульд зайлшгүй тусгах шаардлагатай байна.

11.Одоогийн мөрдөгдөж буй Газрын тухай хуульд гэр бүлийн хамтын хэрэгцээний болон төсөвт байгууллагад зайлшгүй эзэмшүүлэхээс бусад зориулалтаар олгох газрыг дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах журмаар эзэмшүүлэхээр хуульчилсан боловч ямар тохиолдолд дуудлага худалдаа, ямар тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтын журмаар газар эзэмшүүлэх-талаар ялгаа заагийг тодорхойлж тусгаагүй, хэт ерөнхий тусгасан байдлыг өөрчилж нарийвчлан зааж өгөх шаардлагатай.

Мөн Газрын биржээр ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхой бус байгаагаас хуулийн энэхүү заалт өнөөг хүртэл хангалттай хэрэгжихгүй байна.

Иймд төрийн өмчийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, Монгол Улсын иргэд хэрэв хүссэн тохиолдолд газар өмчлөх эрхээ дуудлага худалдаагаар бусдад шилжүүлэх, төрийн өмчийн газрын хувьцааг арилжих зэрэг үйл ажиллагааг газрын биржээр дамжуулан явуулж байх, газрын биржийн үйл ажиллагааны дүрэм, ажиллах журмыг Засгийн газар баталдаг байх зохицуулалтыг шинээр тусгах нь зүйтэй байна.

12.Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тухай хуульд газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тухайлбал, бэлчээрийн нэр томъёог ойлгомжтой, тодорхой тусгах, газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах, түүнд төрийн байгууллага болон иргэд (малчин), аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхой тусгаж, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нөхөн сэргээх, газрын доройтлыг арилгах, мал болон бэлчээрийн зохистой харьцааг бий болгох, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх асуудлыг практик шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, бэлчээрийг нийтээр болон гэрээгээр ашиглах, түүнд хамаарах эрх бүхий этгээдүүдийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

13.Хот, тосгон, бусад суурины газрын нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтын зохицуулалт тодорхойгүйгээс үүдэн нийтийн эдэлбэрийн газрыг зөвшөөрөлгүй дур мэдэн эзэмших, ашиглах зөрчил даамжирч, улмаар эзэнгүйдэх асуудал гарч байгаа тул нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

14.Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарт мониторинг хийж, үнэлэлт дүгнэлт өгөх замаар доройтсон газрыг сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч хэрэгжүүлдэг байх тогтолцоог бий болгох нь зүйтэй байна.

15.Газрын зөрчил маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа цаг хугацаа авдаг тул иргэд залхдаг, шийдвэрлэх гэсээр байтал үл хөдлөх хөрөнгө баригдаж дуусдаг асуудал түгээмэл байна.

Иймд газрын харилцаатай холбоотой зөрчил, маргааны шалтгааныг тодорхойлж, талуудыг зөвшилцөлд хүргүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийг арилгах, маргалдагч талуудыг эвлэрүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус бүтцийг холбогдох байгууллагын төлөөлөлтэйгөөр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн газрын албаны дэргэд байгуулан ажиллуулах нь зүйтэй байна.

16.Хориглосон, хязгаарласан заалтыг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар тусгаж, газрыг доройтуулах, хохирол учруулах, нөхөн сэргээхгүй байгаа зэрэг зөрчилд хохирол тооцох, хяналт шалгалт хийх эрхтэй этгээд, түүний бүрэн эрхийг тодорхой болгож, улмаар хөндлөнгийн мониторинг хийх боломжийг тусган, хяналт шалгалт болон мониторингийн үр дүнгийн дагуу авах арга хэмжээг нарийвчлан тусгах шаардлагатай.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Газрын тухай хууль нь газар болон түүнтэй холбоотой бусад хуулиудын суурь хууль байх тул хуулийн нэрийг Газрын ерөнхий хууль гэж өөрчлөн боловсруулах бөгөөд тус хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойлолт, газрын тухай хууль нь суурь хууль байх тухай, төрөөс газрын талаар баримтлах зарчмын талаар тусгана.

Хоёрдугаар бүлэгт газрын нэгдмэл сан, түүний үндсэн ангилал, удирдлага, газрын ангилал шилжүүлэх үйл ажиллагаа, тусгай хэрэгцээний газар, түүний зориулалт, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, газрын нэгдмэл сангийн удирдлагын гэрээ, түүнийг байгуулах талаар тусгана.

Гуравдугаар бүлэгт төрөөс газрын талаар баримтлах бодлого, газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, түүнд тавигдах шаардлага, хэрэгжилтийг хэрхэн тайлагнах болон газар зохион байгуулалтын санхүүжилт, төлөвлөгөөний ил тод, нээлттэй байдал, хяналтын талаар тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн төрийн өмчийн газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, түүний зориулалт, хэмжээ, газар өмчлөх эрхийг олгох, дуусгавар болгох, шилжүүлэх талаарх зохицуулалтуудыг тусгана.

Тавдугаар бүлэгт төрийн өмчийн газрыг бусдад хязгаартайгаар эзэмшүүлж, ашиглуулах зориулалтыг харгалзан ямар төрлийн эрхээр иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх асуудлыг тусгана. Газрын хязгаарлагдмал эрхийн төрөл, түүний олж авах эрх бүхий этгээд, газрын хязгаарлагдмал эрх буюу газрыг узуфрукт, төрийн өмчийн

газар дээр барилга, барилга байгууламж барих эрх, сервитут тогтоох, олгох, хүчингүй болгох үндэслэл, журам, хугацаа, зориулалт, хэмжээний талаар тусгана.

Зургадугаар бүлэгт төрийн өмчийн газрыг гэрээгээр ашиглуулах этгээдийг тодорхойлж, газар ашиглах гэрээ, түүнд тавигдах шаардлага, газар ашиглуулах хугацаа, газар ашиглуулах шийдвэр гаргах үндэслэл, газрыг гэрээгээр ашигласны төлбөр болон газрыг гэрээгээр ашиглуулах талаар тусгана.

Долдугаар бүлэгт газрын биржийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй тусгана.

Наймдугаар бүлэгт кадастр, түүний агуулга, төрөл, кадастрын үйл ажиллагаа эрхлэх, газрын эрхийн улсын бүртгэл, түүний агуулга, төрөл, газрын мэдээллийн улсын нэгдсэн сан, газрын эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан, газрын эрхийн улсын бүртгэлийн талаар тусгана.

Есдүгээр бүлэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны төрөл, үзүүлэлтүүд, давтамж болон газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ, эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа, үр дүнгээр хэрэгжүүлэх арга хэмжээг тусгана.

Аравдугаар бүлэгт газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нийтлэг шаардлагуудыг тодорхойлж тусгана.

Арван нэгдүгээр бүлэгт газрын нэгдмэл санд тавих төрийн болон олон нийтийн хяналт, газрын маргааныг хянан шийдвэрлэх, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, газрын улсын байцаагчийн эрх, үүрэг, газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд, маргаан таслах зөвлөл, хохирлыг нөхөн төлүүлэх, шилжилтийн үеийн зохицуулалт болон хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар газарт тулгуурласан эдийн засгийн суурь харилцааг зохицуулж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөл бүрдэж, өмчлөгч, ашиглагчийн эрсдэл багасах тул улс орны эдийн засагт томоохон нөлөөг үзүүлэх болно.

Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан боловч тэдгээрийн агуулга, уялдаа холбоо, зарчим, үйл ажиллагааны дараалал, арга зүй, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хуульчилснаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө тус бүрийн агуулга, тэдгээрийн уялдаа холбоо, тавигдах шаардлагыг тодорхой болгохын зэрэгцээ төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих этгээдийн эрх, үүргийн тодорхой болох нөхцөл бүрдэнэ.

Нийгмийн шинэ орчинд зохицсон газрын харилцаа төлөвших бөгөөд газрын асуудал төлөвлөлтөөсөө эхлээд газар олголт, бүртгэл, ашиглалт, үнэ, татвар, төлбөр, хяналт, хамгаалалт хүртэл бүх үйл ажиллагаа нээлттэй, ил тод болно.

Газар өмчлөх, газрыг хязгаартайгаар эзэмшиж ашиглах, газрыг түрээслэх, газрын төлөвлөлт, ашиглалт, хамгаалалтын асуудлууд нэгдсэн зохицуулалттай болж, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилж, уялдаа холбоог хангана. Газрын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг тодорхой болсноор хүний эрх зөрчигдөх, газартай холбоотой хэрэг, маргаан буурах нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын газар нутгийг төлөвлөх, газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр бусдад шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах, бүртгэх, хяналт тавих, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Газрын ерөнхий хууль тогтоомж

2.1.Газрын ерөнхий хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, хүн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Дараах харилцааг энэ хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулна:

3.2.1.газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг, газар нутгийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцаа;

3.2.2.газар зүйн нэртэй холбоотой харилцаа;

3.2.3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх харилцаа;

3.2.4.газрын үнэлгээ, татвар, төлбөртэй холбоотой харилцаа;

3.2.5.кадастр эрхлэхтэй холбоотой харилцаа;

3.2.6.хот байгуулалттай холбоотой харилцаа;

3.2.7.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газрыг нөхөх олговортойгоор солих, эсхүл эргүүлэн авахтай холбоотой харилцаа.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."газар" гэж газрын хөрс, ургамал, ой, ус, хэвлий болон хийн мандлын агаар бүхий орон зайн давхаргыг;

4.1.2.“газар өмчлөх эрх” гэж газрыг хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгаж, захиран зарцуулахыг;

4.1.3.“газрын узуфрукт эрх” гэж төрийн өмчийн газрын үр шимийг нь хүртэх, ашиг олох зорилгоор тодорхой нөхцөл, болзол, хугацаатайгаар өөрийн мэдэлд байлгахыг;

4.1.4.“барилга байгууламж барих газрын эрх” гэж төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих зорилгоор газрыг тодорхой нөхцөл, болзол, хугацаатайгаар өөрийн мэдэлд байлгахыг;

4.1.5.“дундын мэдлийн газрын эрх” гэж хоёр, түүнээс дээш өмчлөгчтэй орон сууц, барилга байгууламжийн доорх болон орчны газрыг дундаа хэсгээр ашиглахаар өөрийн мэдэлд байлгахыг;

4.1.6.“сервитут тогтоох” гэж газрын эрхээ хэрэгжүүлэх, нийгмийн зайлшгүй хэрэгцээг хангах зорилгоор газрын хязгаарлагдмал эрх болон өмчлөх эрхийг хязгаарлахыг;

4.1.7.“газрын төлөв байдал, чанарын хяналт” гэж тухайн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийг анхны үзүүлэлттэй нь харьцуулсан дүгнэлтийг;

4.1.8.“бэлчээр” гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн ангилалд хамааруулсан газрыг;

4.1.9.“отрын нөөц бэлчээр” гэж гамшиг, аюулт үзэгдлийн үед болон нүүдэллэн оторлож ашиглах зориулалтаар эрх бүхий төрийн байгууллагаас тусгайлан тогтоож нөөцөлсөн газрыг;

4.1.10.“бэлчээр ашиглагч” гэж малчин өрх, мал, амьтан бүхий этгээд болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг;

4.1.11.“бэлчээрийн даац” гэж бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр тодорхой хугацааны туршид тухайн газарт бэлчээж болох мал, амьтны тоог;

4.1.12.“дамжин өнгөрөх бэлчээр” гэж мал тууварлах, нүүдэллэхэд зориулсан зурвас бэлчээрийг;

4.1.13.“газрын доройтол” гэж хүний үйл ажиллагаа, байгалийн үйл явц, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн хомсдолын хавсарсан нөлөөгөөр газар элэгдэл, эвдрэлд орж, үржил шим муудан, биологийн болон эдийн засгийн бүтээмжийн чадавхи буурах, алдагдах үйл явцыг;

4.1.14.“кадастр” гэж нэгж талбарт суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хэмжээ, хил зааг, эрх, эрхийн хязгаарлалт, төлөв байдал, чанар, чадавх, үнэлгээ, татвар, төлбөрийн мэдээллийг бүртгэх үйл ажиллагааг.

5 дугаар зүйл.Төрөөс газрын талаар баримтлах зарчим

5.1.Газрын харилцаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр салшгүй бүрэн бүтэн, газрын сан, түүний удирдлага нэгдмэл байх;

5.1.2.газар нь төрийн хамгаалалтад байх;

5.1.3.хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;

5.1.4.газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах;

5.1.5.газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгуулах;

5.1.6. газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх;

5.1.7.газар, байгалийн нөөц, үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийн сан нэгдмэл байх;

5.1.8. газрын талаарх мэдээлэл ил тод, нээлттэй байх.

6 дугаар зүйл.Газар зүйн нэр, хилийн цэс

6.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хилийн цэс, газар зүйн нэрийн зурагтай байна.

6.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг зураглах, бүртгэх, хадгалах, ашиглахтай холбоотой харилцааг Засгийн газраас баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн газар зохион байгуулалт хийх журмаар зохицуулна.

6.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн газар зохион байгуулалтыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, баг, хорооны нутаг дэвсгэрийн хил заагийн газар зохион байгуулалтыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус эрхэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН НЭГДМЭЛ САН, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

7 дугаар зүйл.Газрын нэгдмэл сан, түүний удирдлагын нэгдмэл байдал

7.1.Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн.

7.2.Газрын нэгдмэл сан нь түүний ангилал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь болон газар ашиглалтын зориулалтаас үл хамааран нэгдмэл удирдлагатай байх бөгөөд удирдлагын тогтолцоог энэ хуулиар тогтооно.

8 дугаар зүйл.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал

8.1.Газрын нэгдмэл санг газар ашиглалтын зориулалт, хэрэгцээ болон бүрхэвчээс нь хамааруулан дараах үндсэн ангилалд хуваана:

8.1.1.хөдөө аж ахуйн газар;

- 8.1.2.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар;
- 8.1.3.зам, шугам сүлжээний газар;
- 8.1.4.ойн сан бүхий газар;
- 8.1.5.усны сан бүхий газар.

9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн газар

9.1.Хөдөө аж ахуйн газарт дараах газар хамаарна:

- 9.1.1.бэлчээрийн газар;
- 9.1.2.хадлангийн газар;
- 9.1.3.тариалангийн газар;
- 9.1.4.хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар;
- 9.1.5.хад асга, элсэн манхан, ургамлын бүрхэвчгүй газар;
- 9.1.6.атаржсан газар;
- 9.1.7.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар.

10 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар

10.1.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дараах газар хамаарна:

- 10.1.1.барилга байгууламжийн дэвсгэр газар;
- 10.1.2.нийтийн болон амины орон сууцны байшин, гэр, сууцны доорх газар;
- 10.1.3.зуслангийн газар;
- 10.1.4.нийтийн эдэлбэр газар;
- 10.1.5.дэд бүтцийн газар;
- 10.1.6.аж ахуйн зориулалтай газар;
- 10.1.7.уурхайн эдэлбэр газар;
- 10.1.8.газар доорх байгууламж бүхий газар;
- 10.1.9.ой бүхий газар;
- 10.1.10.ус бүхий газар;
- 10.1.11.цаашид тэлж хөгжих нөөц газар;
- 10.1.12.бусад сул чөлөөтэй газар.

11 дүгээр зүйл.Зам, шугам сүлжээний газар

11.1.Зам, шугам сүлжээний газарт хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын хил заагийн гаднах зам, шугам сүлжээний дараах газар хамаарна:

11.1.1.агаарын, усан, төмөр зам, авто зам, тэдгээрийн сүлжээ, барилга байгууламж, хамгаалалтын бүс, зурвасын;

11.1.2.цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, инженерийн бэлтгэл арга хэмжээ, харилцаа холбоо, мэдээлэл, хий, газрын тосны зэрэг инженерийн шугам сүлжээ, эх үүсвэр, барилга байгууламж, түүний хамгаалалтын бүс, зурвасын.

12 дугаар зүйл.Ойн сан бүхий газар

12.1.Ойн сан бүхий газарт дараах газар хамаарна:

- 12.1.1.ой мод бүхий газар;
- 12.1.2.ойн цоорхой, зурвас газар;

- 12.1.3.бут, сөөг бүхий газар;
- 12.1.4.загтай газар;
- 12.1.5.ой доторх модыг нь огтолсон газар;
- 12.1.6.ой тэлэн ургахад шаардлагатай газар.

13 дугаар зүйл.Усны сан бүхий газар

13.1.Усны сан бүхий газарт дараах газар хамаарна:

- 13.1.1.нуур, цөөрөм, тойром;
- 13.1.2.мөрөн гол;
- 13.1.3.горхи, булаг, шанд, рашаан;
- 13.1.4.мөстөл, мөсөн гол;
- 13.1.5.гол, горхины урсгал шургасан хуурай сайр;
- 13.1.6.намаг;
- 13.1.7.усан сан.

14 дүгээр зүйл.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал тогтоох, газрыг ангилал хооронд шилжүүлэх

14.1.Энэ хуулийн 8.1-д заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газар өөр хоорондоо хил заагтай, бүртгэлтэй байна.

14.2.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрын байршил, хил зааг, хэмжээг тогтоох, ангилал шилжүүлэх асуудлыг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөгөөр Засгийн газар шийдвэрлэнэ.

14.3.Газрын нэгдмэл санг эрхлэх асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд газрын нэгдмэл санг эрхлэх журмыг Засгийн газар батална.

15 дугаар зүйл.Газар ашиглалтын бүсчлэл

15.1.Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газар нь газар ашиглалтын бүсчлэлтэй байна.

15.2.Хөдөө аж ахуйн газар нь газар ашиглалтын зориулалтаасаа хамаарч дараах бүсчлэлтэй байна:

- 15.2.1.уламжлалт мал аж ахуй эрхлэх бүс;
- 15.2.2.эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс;
- 15.2.3.тариалангийн бүс;
- 15.2.4.холимог бүс;
- 15.2.5.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан нөөц бүс.

15.3.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар нь газар ашиглалтын зориулалтаасаа хамаарч дараах бүсчлэлтэй байна:

- 15.3.1.орон сууцны бүс;
- 15.3.2.олон нийтийн бүс;
- 15.3.3.үйлдвэрлэлийн бүс;
- 15.3.4.амралт, аялал жуулчлалын бүс;
- 15.3.5.хөдөө аж ахуйн бүс;

- 15.3.6.зуслангийн бүс;
- 15.3.7.тусгай зориулалтын бүс;
- 15.3.8.онцгой хамгаалалтын бүс;
- 15.3.9.холимог бүс;
- 15.3.10.ногоон бүс.

15.4.Газар ашиглалтын бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрэм, бусад ангиллын газарт дэглэмээр зохицуулна.

15.5.Газар ашиглалтын бүсчлэлийн шалгуур үзүүлэлтийг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өргөн мэдүүлснээр Засгийн газар тогтооно.

15.6.Газар ашиглалтын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дэглэмийг Засгийн газар тогтооно.

16 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газар

16.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Газрыг дараах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч болно:

- 16.1.1.улсын тусгай хамгаалалттай газар;
- 16.1.2.улсын хилийн зурвас газар;
- 16.1.3.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар ашиглах газар;

- 16.1.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгох газар;

- 16.1.5.шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын газар;

- 16.1.6.аймаг дундын отрын бэлчээр;
- 16.1.7.хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар;
- 16.1.8.газрын тос, уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт ашиглалтын талбай;

- 16.1.9.чөлөөт бүсийн газар;
- 16.1.10.нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс;
- 16.1.11.олон улсын болон үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар;

- 16.1.12.цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгох газар;

- 16.1.13.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар.

16.2.Газрыг дараах зориулалтаар аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг үндэслэн орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно:

- 16.2.1.цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах зориулалтаар ашиглах газар;

- 16.2.2.сум дундын отрын бэлчээр, хадлангийн талбайн зориулалтаар ашиглах газар;

16.2.3.түүх, соёлын дурсгалт болон амьтан, ургамал, ой, усны нөөцийг хамгаалах газар.

16.3.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын аль ч газраас улс болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

16.4.Улсын тусгай хэрэгцээний газартай давхцуулан орон нутгийн тусгай хэрэгцээнд авахыг хориглоно.

16.5.Орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцуулан газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр гарснаар тухайн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнээс гарсанд тооцно.

16.6.Энэ хуулийн 16.1.1, 16.1.2, 16.1.6, 16.1.8, 16.1.9, 16.1.10, 16.1.11-д заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол иргэнд өмчлүүлсэн, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлсэн болон гэрээгээр ашиглуулж байгаа газартай давхцаж болно.

16.7.Энэ хуулийн 16.6-д зааснаас бусад зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газарт иргэнд өмчлүүлсэн, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлсэн болон гэрээгээр ашиглуулж байгаа газартай давхцалгүй байна.

16.8.Газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах, тусгай хэрэгцээний газрыг ашиглах журмыг Засгийн газар батална.

16.9.Газрыг улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шалгуур үзүүлэлтийг энэ хуулийн 16.8-д заасан журмаар тогтооно.

17 дугаар зүйл.Газрыг тусгай хэрэгцээнд авах

17.1.Энэ хуулийн 16.1.1-16.1.4-т заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, байршил, хил заагийг тогтоох асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

17.2.Энэ хуулийн 16.1.5-16.1.13-т заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, байршил, хил заагийг тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

17.3.Газрыг тусгай хэрэгцээнд авах шийдвэрт тухайн газарт мөрдөх дэглэм, горимыг тодорхой заана.

17.4.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авахад дараах шаардлагыг хангасан байна:

17.4.1.улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байх;

17.4.2.улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан байх.

17.5.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагад гаргана.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан хүсэлтэд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ:

17.6.1.энэ хуулийн 16.1.9-16.1.13-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл;

17.6.2.энэ хуулийн 16.1.1-16.1.8-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээ, хил заагийг тогтоох үндэслэл, судалгаа;

17.6.3.тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй хүн, хуулийн этгээдэд олгох нөхөх олговор, нүүлгэн шилжүүлэлтийн зардалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоо;

17.6.4.бусад холбогдох баримт бичиг.

17.7.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 17.6-д заасан баримт бичгийг газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар дүгнэлт гаргуулахаар газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

17.8.Энэ хуулийн 17.7-д заасан материалыг хүлээн авсан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

17.8.1.улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээ, хил заагийг тодорхойлох;

17.8.2.нөлөөлөлд өртөж буй хүн, хуулийн этгээдэд олгох нөхөх олговор, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой нарийвчилсан судалгааг хийж, газар болон үл хөдлөх хөрөнгийн урьдчилсан үнэлгээг гаргах;

17.8.3.нөлөөлөлд өртөж буй хүн, хуулийн этгээдтэй хэлцэл хийх;

17.8.4.тухайн нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санал авах;

17.8.5.газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар дүгнэлт гаргах.

17.9.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах асуудлыг Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана.

17.10.Газрыг энэ хуулийн 16.2-т заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуульд заасан шаардлагыг хангасан саналыг боловсруулж өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

17.11.Аймаг, нийслэлийн Засаг дарга газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах саналаа энэ хуулийн 17.6.2-17.6.4-т заасан баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

17.12.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 17.8.1-17.8.3, 17.8.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санал авсан байна.

18 дугаар зүйл.Тусгай хэрэгцээний газрыг ашиглах

18.1.Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

18.2.Энэ хуулийн 16.1.1, 16.1.6 16.1.9-д зааснаас бусад улсын тусгай хэрэгцээний газарт газар ашиглуулах шийдвэрийг энэ хуулийн 17.5-д заасан холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах шийдвэр гаргаж, газар ашиглуулах гэрээ байгуулна.

18.3.Энэ хуулийн 16.1.1-д заасан улсын тусгай хэрэгцээний газарт газар ашиглуулахыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, 16.1.6-д заасан газарт газар ашиглуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарын саналыг үндэслэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, 16.1.9-д заасан газарт Чөлөөт бүсийн захирагч шийдвэрлэж, газар ашиглуулах гэрээ байгуулна.

18.4.Энэ хуулийн 18.2, 18.3-т заасан шийдвэрийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд бүртгэнэ.

19 дүгээр зүйл.Газрыг тусгай хэрэгцээнээс гаргах

19.1.Газрыг дараах үндэслэлээр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь тусгай хэрэгцээнээс гаргаж болно:

19.1.1.тусгай хэрэгцээний газрын хил зааг, талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн;

19.1.2.газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хэсэгчлэн болон бүхэлд нь буцаасан, хугацаа дуусгавар болсон, гэрээг цуцалсан;

19.1.3.үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр хэрэгжсэн.

20 дугаар зүйл.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо

20.1.Газрын нэгдмэл санг нэгдсэн төлөвлөлт, удирдлагаар хангаж, зохион байгуулах асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

20.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлд газар /цаашид “аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэх/, дүүрэгт хэлтэс, суманд газар зохион байгуулагчтай байна.

20.3.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.

20.4.Дүүргийн хэлтсийн даргыг нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн Засаг даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө.

20.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг газрын харилцааны мэргэжилтэй, мэргэжлээрээ төрийн албанд 8-аас доошгүй, түүнээс удирдах албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

20.6.Дүүргийн хэлтсийн даргыг газрын харилцааны мэргэжилтэй, мэргэжлээрээ төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

20.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн ам болон нэгж талбарын тоог харгалзан аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх газрын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын орон тооны жишиг нормативыг Засгийн газар тогтооно.

20.8.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

21 дүгээр зүйл.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

21.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан газрын талаарх зорилго, зорилтыг хэрэгжүүлэх;

21.1.2.газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

21.1.3.газрын харилцааны хууль тогтоомжийг сурталчлах, боловсронгуй болгох санал боловсруулж, танилцуулах;

21.1.4.гадаад улс, олон улсын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;

21.1.5.Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд эрхэлсэн асуудлын хүрээнд дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангах;

21.1.6.салбарын хүний нөөцийн бодлогыг эрхлэх, албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдгээрийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

21.1.7.бүх шатны газрын байгууллага, газар зохион байгуулагчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

21.1.8.газар зохион байгуулалт, газрыг доройтлоос хамгаалах, газар хамгаалах, газрын доройтлыг нөхөн сэргээх үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих;

21.1.9.нэгж талбарын хувийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, эрхлэх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;

21.1.10.бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох байгууллагыг мэргэжлийн зөвлөмж, чиглэлээр хангах;

21.1.11.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагааг эрхлэх, хөгжүүлэх, хяналт тавих, олон нийтэд мэдээллээр үйлчлэх;

21.1.12.газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, түүний өөрчлөлтийг ажиглах, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий газрын мониторингийн хяналт-шинжилгээний улсын сүлжээг байгуулж, ажиллуулах;

21.1.13.газрын асуудлаар ирсэн өргөдөл, гомдол, хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэх;

21.1.14.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх;

21.1.15.газар зохион байгуулалт, газрын кадастрын судалгаа, шинжилгээний ажил эрхлэх;

21.1.16.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;

21.1.17.газрын биржийн үйл ажиллагааг Засгийн газраас баталсан дүрмийн дагуу зохион байгуулах;

21.1.18.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

21.1.19.газрыг хязгаарлагдмал эрхээр болон гэрээгээр газар ашиглаж буй хүн, хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар нийтэд нээлттэй мэдээлэх;

21.1.20.газрын төлбөрийг ногдолын мэдээллийг татварын албанд хуульд заасны дагуу хүргүүлэх ажлыг зохион байгуулах.

22 дугаар зүйл.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх

22.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах;

22.1.2.аймаг, нийслэл дэх газар, нэгжийн бүтэц, орон тоог батлах;

22.1.3.аймаг, нийслэл дэх хэлтсийн дарга, албан хаагчид, газар зохион байгуулагчийг томилж, чөлөөлөх;

22.1.4.нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;

22.1.5.газрын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх;

22.1.6.газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

22.1.7.газрын төлбөр ногдуулах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах;

22.1.8.хууль тогтоомжид заасан бусад.

23 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг

23.1.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулах, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;

23.1.2.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулах;

23.1.3.хүн, хуулийн этгээдийн газартай холбоотой гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;

23.1.4.Монгол Улсын иргэнд газрыг өмчлөх эрхээр шилжүүлэх шийдвэр гаргах;

23.1.5.газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагчид газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, газар ашиглуулах шийдвэр гаргах;

23.1.6.газрыг Монгол Улсын иргэнд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх шийдвэр гаргах;

23.1.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтаар газар ашиглуулах шийдвэр гаргах;

23.1.8.газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглуулах гэрээг дуусгавар болгох шийдвэр гаргах;

23.1.9.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг зохих журмын дагуу хөтлөх, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх;

23.1.10.орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан, гаргасан газрын хэмжээ, байршил, эргэлтийн цэгүүдийн солбицлыг газар дээр нь тогтоож, холбогдох мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд бүртгэх;

23.1.11.Газрын ерөнхий хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, хүн, хуулийн этгээдийн гэрээний үүргийн биелэлт, газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах;

23.1.12.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хүн, хуулийн этгээдэд олгосон газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах ажлыг зохион байгуулах;

23.1.13.хүн, хуулийн этгээдэд мод тарих, үржүүлэх, ойжуулах зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах;

23.1.14.газрын төлбөрийн ногдуулалтад хяналт тавьж ажиллах.

23.1.15.газар өмчлөх эрх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулах шийдвэрийг эд хөрөнгийн эрхийн дундын мэдээллийн санд илгээнэ.

24 дүгээр зүйл.Газар зохион байгуулагч, түүний чиг үүрэг

24.1.Газар зохион байгуулагч дараах чиг, үүрэгтэй:

24.1.1.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж сумын Засаг даргад танилцуулах;

24.1.2.сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж сумын Засаг даргад танилцуулах;

24.1.3.аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн хүн, хуулийн этгээдэд газрын төлбөр ногдуулах, төлөлтөд хяналт тавих, гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, цахим болон цаасан хувийн хэрэг үүсгэж, хөтлөх, баяжилт хийх;

24.1.4.газар өмчлөх эрх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлсэн болон гэрээгээр ашиглуулахаар шийдвэрлэсэн газрын хэмжээ, байршил, эргэлтийн цэгийн солбицлыг газар дээр нь тогтоолгож, актаар хүлээлгэн өгөх, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд оруулах;

24.1.5.газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах, бусдад ашиглуулах хүсэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авч, газрын мэдээллийн системд бүртгэх;

24.1.6.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг зохих журмын дагуу хөтлөх, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх;

24.1.7.газрын харилцааны асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэх;

24.1.8.газрын талаарх мэдээлэл, лавлагааг хууль тогтоомжид заасны дагуу гаргаж өгөх;

24.1.9.газрын хязгаарлагдмал эрхтэй хүн, хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг, гэрээгээр газар ашиглагч хүн, хуулийн этгээдийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

24.1.10.гэрээгээр газар ашиглагч хүн, хуулийн этгээдийн гэрээний үүргийн хэрэгжилтийг 2 жил тутамд дүгнэх;

24.1.11.газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

24.1.12.Газрын ерөнхий хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөн хүн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох саналаа холбогдох албан тушаалтанд хүргүүлэх;

24.1.13.хуульд заасан хугацаанд гэрээгээ дүгнүүлээгүй, газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн хүн, хуулийн этгээдийн газар ашиглах гэрээг дуусгавар болгох саналаа холбогдох албан тушаалтанд хүргүүлэх;

24.1.14.газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглагч этгээдэд газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр дамжуулан газрын төлбөрийн ногдуулалтыг хуульд заасны дагуу хийх.

25 дугаар зүйл.Газар зохион байгуулалт

25.1.Газрын нэгдмэл сангийн удирдлагыг газар зохион байгуулалтын дараах арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

25.1.1.төлөвлөх;

25.1.2.газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, газрыг гэрээгээр ашиглуулах;

25.1.3.кадастр эрхлэх;

25.1.4.газрын төлөв байдал, чанарт хяналт тавих;

25.1.5.газрыг хамгаалах, нөхөн сэргээх;

25.1.6.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг эрхлэх;

25.1.7.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем эрхлэх.

26 дугаар зүйл.Газар зохион байгуулалтын санхүүжилт

26.1.Газар зохион байгуулалтын арга хэмжээг дараах журмаар санхүүжүүлнэ:

26.1.1.улсын болон орон нутгийн төсөв, газрын биржийн орлогоос;

26.1.2.хүн, хуулийн этгээд газрын хязгаарлагдмал эрхээр болон газар ашиглах гэрээгээр ашиглаж байгаа газарт хийлгэх газар зохион байгуулалтын үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөөр;

26.1.3.олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар.

26.2.Газар зохион байгуулалтын ажлын норм, үнэлгээг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний хөлс, хураамжийг Засгийн газар батална.

27 дугаар зүйл.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем

27.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем /цаашид “газрын мэдээллийн систем” гэх/-ийг эрхэлнэ.

27.2.Газрын мэдээллийн систем нь дараах мэдээллийн системээс бүрдэнэ:

- 27.2.1.эрдэс баялаг, нөөцийн мэдээллээс бусад газрын;
- 27.2.2.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний;
- 27.2.3.газрын биржийн;
- 27.2.4.кадастрын;
- 27.2.5.газрын үнэлгээ, татвар, төлбөрийн;
- 27.2.6.газрын төлөв байдал, чанарын мониторингийн;
- 27.2.7.хаягийн.

27.3.Газрын мэдээллийн систем нь байрлалд суурилсан, Геодези, зураг зүйн тухай хуульд заасан собицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд тулгуурлан үйлдэгдсэн газрын талаарх бүх өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдэл байна.

27.4.Газрын мэдээллийн системийн сүлжээ эвдрэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд төрийн өмчид хамаарна.

27.5.Энэ хуульд заасан төрийн байгууллагын эрх бүхий этгээд нь газрыг төлөвлөх, газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах, газрын татвар, төлбөр ногдуулах, төлөлтөд хяналт тавих, гэрчилгээ, кадастрын зураг, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, хувийн хэрэг үүсгэх, баяжилт хийх тэдгээртэй холбоотой үйл ажиллагааг газрын мэдээллийн системээр дамжуулан зохион байгуулна.

27.6.Газрын мэдээллийн систем нь дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай эд хөрөнгийн эрхийн бүртгэл болон хаягийн, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай газрын үнэлгээ, татвар, төлбөрийн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай төрийн өмчид бүртгэлтэй эд хөрөнгийн бүртгэлийн асуудлаар өдөр тутам мэдээлэл солилцох үйл ажиллагааг хангаж ажиллана.

27.7.Газрын мэдээллийн систем дэх мэдээлэл нь хуулиар хязгаарласнаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

27.8.Газрын мэдээллийн системийн үйл ажиллагааны журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27.9.Газрын мэдээллийн системийн хуулбар сан, түүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага хариуцна.

27.10.Газрын мэдээллийн систем нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын олон улсын стандартад нийцсэн байна.

28 дугаар зүйл.Газрын мэдээллийн системд тавигдах шаардлага

28.1.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийн систем дараах шаардлагыг хангасан байна:

28.1.1.бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд ил тод, нээлттэй ашиглах боломжтой байх;

28.1.2.хүн, хуулийн этгээдийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран санал өгөх, хүсэлтээ гаргах боломжтой байх;

28.1.3.салбар хоорондын төлөвлөлтийг уялдуулах, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх;

28.1.4.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, газрыг гэрээгээр ашиглуулах асуудлыг шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн байх.

28.2.Газрын биржийн мэдээллийн систем дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1.газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж, хүн, хуулийн этгээд орон зай, цаг хугацаанаас үл хамааран оролцох, өрсөлдөөнийг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэн байх;

28.2.2.цаг хугацаа, зардал хэмнэх;

28.2.3.газрын зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулах боломжтой байх;

28.2.4.газар, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал, зар мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах боломжтой байх.

28.3.Кадастрын мэдээллийн систем дараах шаардлагыг хангасан байна:

28.3.1.газар өмчлөх, хүн, хуулийн этгээдээс газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглах хүсэлт гаргах, хүсэлтийн явцыг хянах боломжийг бүрдүүлсэн байх;

28.3.2.хүн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулах;

28.3.3.газартай холбоотой лавлагаа, мэдээлэл, тодорхойлолтыг авах боломжтой байх;

28.3.4.үйлчилгээ болон улсын тэмдэгтийн хураамжийг төлөх, хянах боломжтой байх;

28.3.5.нэгж талбарт суурилсан байх.

28.4.Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн мэдээллийн систем дараах шаардлагыг хангасан байна:

28.4.1.нэгж талбар бүрээр газрын зах зээлийн үнэ, үнэлгээг хөтлөх, газрын төлбөр, татварыг ногдуулах, төлөх боломжийг бүрдүүлсэн байх;

28.4.2.газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээг нэгж талбар бүрээр нөлөөлж байгаа хүчин зүйлийг харгалзан системээс хийх боломжтой байх;

28.4.3.газрын төлбөр, татвар, үйлчилгээний хураамж төлөлтөд хянах тавих боломжийг бүрдүүлсэн байх;

28.4.4.газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт, лавлагааг авах боломжтой байх;

28.4.5.газрын үнэлгээ, төлбөрийн бүсчлэл, газрын төлбөр, татварын мэдээллийг харах боломжтой байх.

28.5.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн мэдээллийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

28.5.1.газрын төлөв байдал, чанарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл нь ил тод, нээлттэй байх;

28.5.2.газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээг ажиллуулж, газрын доройтлыг тодорхойлох боломжтой байх;

28.5.3.зайнаас тандах технологийг ашиглах боломжтой байх;

28.5.4.газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар зөвлөмж гаргах боломжийг бүрдүүлсэн байх.

28.6.Хаягийн мэдээллийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

28.6.1. газар, үл хөдлөх эд хөрөнгөд төлөвлөлт, бүртгэлийн үе шатнаас эхлэн системээс хаяг олгох, хяналт тавих боломжтой байх;

28.6.2.олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх;

28.6.3.хүн, хуулийн этгээд болон төрийн байгууллагууд дундын мэдээллийн сангаар дамжуулан ашиглах боломжтой байх;

28.6.4.хаягт суурилсан замчлах системийг ашиглах боломжийг бүрдүүлсэн байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

29 дүгээр зүйл. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө

29.1. Энэ хуулийн 25.1.1-д заасан арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө дараах төрөлтэй байна:

29.1.1. улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;
29.1.2. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;
29.1.3. сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;
29.1.4. улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө;
29.1.5. аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө;
29.1.6. сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө;
29.1.7. улсын тусгай хамгаалалттай газрын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө.

29.2. Энэ хуулийн 29.1-д заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь тайлбар бичиг, зураг, бүдүүвч, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон бусад холбогдох баримт бичгээс бүрдэнэ.

29.3. Энэ хуулийн 29.1.7-д заасан ерөнхий төлөвлөгөөг боловсруулах журмыг газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

29.4. Энэ хуулийн 29.1.1-29.1.3, 29.1.7-д заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг дараах этгээд батална:

29.4.1. энэ хуулийн 29.1.1-д заасан төлөвлөгөөний ажлын даалгаврыг Ерөнхий сайд;

29.4.2. энэ хуулийн 29.1.2-т заасан төлөвлөгөөний ажлын даалгаврыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран;

29.4.3. энэ хуулийн 29.1.3-т заасан ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга сумын Засаг даргатай хамтран;

29.4.4. энэ хуулийн 29.1.7-д заасан ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран.

29.5. Энэ хуулийн 29.1.1-29.1.4-т заасан төлөвлөгөөг боловсруулах аргачлалыг газрын асуудал эрхэлсэн Засгийн гишүүн, 29.1.5, 29.1.6-д заасан төлөвлөгөө боловсруулах аргачлалыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тус тус батална.

29.6. Бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

29.7. Энэ хуулийн 29.1.1-29.1.3, 29.1.7-д заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хугацаа нь дуусгавар болохоос 6 сарын өмнө шинэчлэн баталсан байна.

29.8.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх талаар дүгнэлт гаргана.

29.9.Энэ хуулийн 29.1.2, 29.1.7-д заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.

29.10.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичиг болон хэрэгжилтэд дараах этгээдүүд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

29.10.1.улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж хөндлөнгийн хяналтаар;

29.10.2.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

29.10.3.сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

29.10.4.энэ хуулийн 16.1.1-д заасан улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

29.11.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.12.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгож болно:

29.12.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт өөрчлөлт орсон, шинэчлэгдсэн;

29.12.2.улс, орон нутгийн төсөвт өөрчлөлт орсон;

29.12.3.дээд шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон, шинэчлэгдсэн;

29.12.4.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжөөр түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь тогтоогдсон.

30 дугаар зүйл.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлага

30.1.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтлах бөгөөд дараах нийтлэг шаардлагад нийцсэн байна:

30.1.1.хүний эрүүл, аюулгүй байдал, байгаль, экологийн тэнцвэрт байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах;

30.1.2.улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаж, түүний зорилго, зорилтыг хэрэгжүүлэх;

30.1.3.салбар хоорондын уялдаа, иргэд, олон нийтийн оролцоог хангах;

30.1.4.газар, байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл, дэд бүтцийн хүртээмж, нөөцийн судалгаа шинжилгээ, үнэлгээнд үндэслэх;

30.1.5.газрын өмчийн хэлбэр, ашиглалтын зориулалтыг үл харгалзан газрын нэгдмэл сангийн бүх ангилалаар төлөвлөх;

30.1.6.газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний зураг төслийг боловсруулах журам, заавар, аргачлалд нийцсэн байх;

30.1.7.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг төсөл, түүнтэй холбоотой бусад суурь судалгааны мэдээллийг геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд үйлдэх;

30.1.8.оновчтой төлөвлөлтийн хувилбаруудыг дэвшүүлж, түүний зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг тодорхойлох;

30.1.9.газар зохион байгуулалтын төлөвлөгөөг энэ хуулийн 27.2.2-т заасан системээр дамжуулан боловсруулсан байх.

31 дүгээр зүйл.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

31.1.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар, байгалийн нөхцөл, нөөц, түүний экологи, нийгэм, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхид зохицсон, газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 30 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

31.2.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 29.1.2-29.1.7-д заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэс болох бөгөөд ерөнхийгөөс нарийвчлах, нарийвчилснаас ерөнхий байх зарчмаар нутаг дэвсгэрийн нэгжээр шатлан боловсруулж хэрэгжүүлнэ.

31.3.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь газрын байршил, хэмжээ, хил заагийн бүдүүвч зураг, холбогдох тооцоо, шийдлийг тусгасан дараах агуулгатай байна:

31.3.1.нүүдлийн хэв маягийг хадгалсан, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх бүс нутаг, баримтлах бодлого;

31.3.2.эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх кластерын систем нэвтрүүлэх бүс нутаг, үндэсний хэмжээний агро-технологийн төрөлжсөн парк байгуулах газар;

31.3.3.эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх бүс нутаг, түүнд баримтлах бодлого;

31.3.4.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх бүс нутаг, баримтлах бодлого;

31.3.5.улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээр, аймаг дундын отрын бэлчээр, улсын нөөцийн хадлангийн талбай;

31.3.6.хот, тосгон бусад сууриныг шинээр бий болгох, өөрчлөн шинэчлэх, нүүлгэн шилжүүлэх, эдэлбэр газрыг өөрчлөх, тэдгээрийн орон сууц, дэд бүтцийн хангамж, баримтлах бодлого;

31.3.7.хүнд үйлдвэр хөгжүүлэх бүс нутаг, баримтлах бодлого, үйлдвэрлэл технологийн парк байгуулах газар;

31.3.8.улсын чанартай зам, шугам сүлжээ, тээврийн сүлжээ, тэдгээрийн дэд бүтэц болон зурвас газар;

31.3.9.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар, газрын тос, уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ашиглуулах газар;

31.3.10.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос эрх хайх, ашиглахыг хориглох бүс нутаг, ашиглах дэглэм;

31.3.11.газрын тос, уламжлалт бус газрын тос, байгалийн хий болон ус дамжуулах хоолойн барилга байгууламж, тэдгээрийн зурвас газар;

31.3.12.ойн сан, усан сан бүхий газрын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, шинээр ойжуулах, ойн зурвас байгуулах бүс нутаг, баримтлах бодлого;

31.3.13.гол, мөрний урсац бүрэлдэх эх, түүний байршил, хэмжээ, хил зааг, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ;

31.3.14.аялал жуулчлал, амралт, сувилал, агнуурын аж ахуйн газар нутгийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх зориулалтаар ашиглах, хамгаалах газар, хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлого;

31.3.15.цөлжилтөөс сэргийлэх, сааруулах, тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүс нутаг;

31.3.16.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, хилийн цэсийг өөрчлөх, тодотгох хувилбар, шийдэл;

31.3.17.байгалийн ургамал тарималжуулах бүс нутаг;

31.3.18.зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн зам;

31.3.19.улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах газар, баримтлах бодлого;

31.3.20.газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах эрх зүйн баримт бичгийн жагсаалт.

31.4.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулах бөгөөд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

31.5.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, Засгийн газар 5 жил тутамд батална.

31.6.Засгийн газар улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг Монгол Улсын Их Хуралд 5 жил тутам танилцуулна.

32 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

32.1.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 15 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

32.2.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг энэ хуулийн 31.3-т заасан хүрээнд нарийвчлан төлөвлөх бөгөөд дараах агуулгатай байна:

32.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээний энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан газар ашиглалтын бүсчлэл, түүнд тавигдах шаардлага;

32.2.2.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал шилжүүлэх газрын байршил, хэмжээ, хил зааг, уг ажлын хүрээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлын төрөл, төсөв;

32.2.3.тариаланд тохиромжтой атар газрын байршил, хэмжээ, хил зааг, хэрэгжүүлэх арга хэмжээ;

32.2.3.орон нутгийн чанартай зам, шугам сүлжээний газрын байршил, хэмжээ, хил зааг;

32.2.4.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл олгох болон олгохыг хориглох газрын байршил, хэмжээ, хил зааг;

32.2.5.сум, дүүргийн хилийн цэсэд өөрчлөлт оруулах, тодотгох хувилбар;

32.2.6.орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах газрын хэмжээ, байршил, ашиглах, хамгаалах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ.

32.3.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж, аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэнээр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

32.4.Энэ хуулийн 32.1-д заасан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 жил тутам тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

32.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 32.1-д заасан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 5 жил тутам газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг,

нийслэлийн Засаг даргаар уламжлуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

33 дугаар зүйл.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүний агуулга

33.1.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 7 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

33.2.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна.

33.3.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг энэ хуулийн 32.2-т заасан хүрээнд нарийвчлан төлөвлөх бөгөөд дараах агуулгатай байна:

33.3.1.газар ашиглалтын бүсчлэл, түүнд тавигдах шаардлага;

33.3.2.өвөл, хавар, зун, намарт хуваарилан ашиглах бэлчээрийн хил зааг, түүнийг сэлгэн ашиглах хуваарь, хугацаа болон бэлчээрлүүлэх малын тоо, төрөл;

33.3.3.мал тууварлах, бэлчээх зорилгоор бусдын газрыг дамжин өнгөрөх бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.3.4.байгалийн тогтоцоор бий болсон нийтээр ашиглах гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээрийн байршил, хэмжээ, хил зааг;

33.3.5.хөдөө аж ахуйн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

33.3.6.зэрлэг амьтдын нүүдэл, шилжилтийн холбоос нутаг, үржил, идэш тэжээлийн түшиц газрын хил зааг;

33.3.7.отрын нөөц нутгийн байршил, хэмжээ, хил зааг, даац, багтаамж;

33.3.8.сум, багийн чанартай хадлангийн газар, хадах боломжтой бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.3.9.усан хангамжийг сайжруулах бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.3.10.сум, баг улирлын бэлчээрийн хэмжээнд тооцсон сүргийн зохистой бүтэц, эргэлт, малын гаралтай бүтээгдэхүүн борлуулалтын орлогын тооцоо;

33.3.11.газар тариалан, жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх байршил, хэмжээ, хил зааг;

33.3.12.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай газар зохион байгуулалтын арга хэмжээ, үйл ажиллагаа;

33.3.13.зам, шугам сүлжээ, тэдгээрийн дэд бүтэц байгуулах газрын хэмжээ, байршил;

33.3.14.ойн сан бүхий газар, түүний ашиглалт, хамгаалалтын бүсийн хил зааг, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.3.15.ойжуулах, ойн зурвас байгуулах, ойн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.3.15.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн хил зааг, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.3.16.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, хориглох, хязгаарлах газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.3.17.орон нутгийн тусгай хэрэгцээнд шинээр авах, гаргах газрын байршил, хэмжээ, хил зааг, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.3.18.амралт, рашаан сувилал, аялал жуулчлал, ан агнуурын бүсийн байршил, хэмжээ, хил зааг, маршрут, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.3.19.газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнд үндэслэн газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газрын байршил, хэмжээ

33.3.20.бусад.

33.4.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, сумын Засаг даргын өргөн мэдүүлсэнээр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

33.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 33.1-д заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон сумын Засаг даргаар уламжлуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

34 дүгээр зүйл.Улсын тусгай хамгаалалттай газрын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

34.1.Улсын тусгай хамгаалалттай газрын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь тухайн газрын бүрдэл хэсэг болох газрын хэвлий, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан болон байгалийн бусад баялгийг хамгаалах, ашиглах 15 жилийн хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлтийн баримт бичиг байна.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах асуудлыг энэ хуулийн 29.3-т заасан журмын дагуу зохион байгуулна.

34.3.Энэ хуулийн 34.1-д заасан ерөнхий төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газар батална.

35 дугаар зүйл.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

35.1.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь улсын хэмжээнд улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилдээ хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

35.2.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:

35.2.1.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн төсөв, олон улсын зээл, тусламжид хамрагдахаар тусгагдсан байх;

35.2.2.улс, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын болон хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байх;

35.2.3.техник, эдийн засгийн үндэслэл, байршил, хэмжээ, хил заагийг нарийвчлан тогтоосон зураг төсөлтэй байх.

35.3.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө дараах агуулгатай байна:

35.3.1.улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессын гэрээгээр хийгдэх инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

35.3.2.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн байршил, хэмжээ, хил зааг;

35.3.3.улсын тусгай хамгаалалттай газар нутаг, чөлөөт бүс болон бусад тусгай хэрэгцээний газарт гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

35.3.4.газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой, геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх газрын байршил, төсөв;

35.3.5.Монгол Улсын иргэнд шинээр өмчлүүлэх газрын байршил, хэмжээ;

35.3.6.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан чөлөөлөх газрын байршил, хэмжээ, хил зааг, нөхөх олговрын хэмжээ, төсөв;

35.3.7.газрын төлбөрийн хэмжээ, түүнээс газар зохион байгуулалт, кадастрын ажил, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулах төсөвт өртгийн тооцоо;

35.3.8.улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах газрын байршил, хэмжээ, хил зааг;

35.3.9.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал шилжүүлэх байршил, хэмжээ, хил зааг;

35.3.10.төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

35.3.11.бусад.

35.4.Салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь эрхлэх асуудлынхаа хүрээнд улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээний саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

35.5.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналаа 8 дугаар сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

35.6.Энэ хуулийн 35.4, 35.5-д заасан саналыг нэгтгэн, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 27.1-д заасан газрын мэдээллийн системээр дамжуулан 9 дүгээр сарын 1-ний дотор олон нийтэд нээлттэй байршуулна.

35.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 35.3-д заасан төлөвлөгөөний төслийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, гарсан саналыг нэгтгэн, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 10 дугаар сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Энэ хугацаанд саналаа ирүүлээгүй тохиолдолд тусгайлсан саналгүйд тооцно.

35.8.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, Засгийн газар жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор батална.

36 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

36.1.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг жилдээ хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан жилийн төлөвлөгөө нь улс, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө байна.

36.3.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

36.4.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх болон гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээг нарийвчлан тогтоож, нэгж талбар бүрээр төлөвлөсөн байна.

36.5.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байна:

36.5.1.газар ашиглалтын бүсчлэлийн дэглэм, дүрмийн дагуу хүн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

36.5.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох газрын байршил, хэмжээ;

36.5.3.орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах газрын хэмжээ, байршил, нөхөн олговрын тооцоо;

36.5.4.газар чөлөөлөлт хийх газрын хэмжээ, байршил, түүнд шаардагдах төсөв;

36.5.5.зам, шугам сүлжээ, тэдгээрийн дэд бүтэц байгуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

36.5.6.шинээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах газрын байршил, хэмжээ;

36.5.7.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай газар зохион байгуулалтын арга хэмжээ, үйл ажиллагаа;

36.5.8.гэр хорооллын дахин төлөвлөлт хийх, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих газрын байршил хэмжээ, төсөв;

36.5.9.газрын доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ, төсөв;

36.5.10.гэрээгээр ашиглуулах хадлангийн газрын байршил, хэмжээ, ашиглах хугацаа;

36.5.11.сум дундын отрын нөөц нутгийн даац, багтаамж, ашиглах улирал, оторлох хугацаа, ус хангамжийн байршил;

36.5.12.мод тарих, үржүүлэх, ойжуулах зориулалтаар гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ;

36.5.13.хөгжүүлэх газрын байршил, хэмжээ, төсөв.

36.5.14.бусад.

36.6.Дараах тохиолдолд аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд газрыг хүн, хуулийн этгээдэд газрын хязгаардмал эрхээр шилжүүлэх арга хэмжээ төлөвлөхийг хориглоно:

36.6.1.хөдөө аж ахуйн газрын үндсэн ангилалд хамаарах газарт хот, тосгон, бусад суурины ангилалд хамаарах зориулалтаар,

36.6.2.бэлчээрийн газарт тариалангийн зориулалтаар;

36.6.3.энэ хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалт, эрүүл ахуйн бүс, зурвас газрын дэглэм, горимыг зөрчсөн;

36.6.4.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байршилд хот, тосгон, бусад суурины ангилалд хамаарах зориулалтаар.

36.7.Сум, дүүргийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналаа тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

36.8.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын дараа оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.

36.9.Энэ хуулийн 36.8-д заасан төлөвлөгөөний төсөл болон тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.

37 дугаар зүйл.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

37.1.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь аймгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд үндэслэн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг жилдээ хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан төлөвлөгөө нь улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө байна.

37.3.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө дараах агуулгатай байна:

37.3.1.бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах, ашиглалтаас чөлөөлөх хуваарь, хил зааг, байршил, бэлчээрлүүлэх малын тоо, төрөл, ашиглагчдын мэдээлэл;

37.3.2.малын тоог бэлчээрийн даац, чадавхид тохируулах, бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

37.3.3.хадлангийн газрыг зохистой ашиглах, сайжруулах байршил, өнжөөж амраах улирал, хугацаа;

37.3.4.хадлан хадах зориулалтаар гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

37.3.5.сумын отрын нөөц нутгийн даац, багтаамж, ашиглах улирал, оторлох хугацаа, ус хангамжийн байршил;

37.3.6.газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнд үндэслэн газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газрын байршил, хэмжээ;

37.3.7.бусад.

37.4.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг сумын Засаг дарга зохион байгуулна.

37.5.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг, өмнөх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал оны эхний хагаст багтаан батална.

37.6.Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг дараа оны сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө батлагдах хүртэл хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЭХ

38 дугаар зүйл.Газар өмчлөх эрх

38.1.Төр өөрийн өмчийн газраас зөвхөн Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэнд өмчлүүлж болно.

38.2.Монгол Улсын иргэнд өмчлүүлсэнээс бусад газар нь төрийн нийтийн өмч /цаашид “төрийн өмчийн газар” гэх/ байх бөгөөд төрийн өмчийн газрын өмчлөгч нь төр байна.

38.3.Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхэд газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц хамаарахгүй.

38.4.Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр зохицуулж, хязгаарлана.

38.6.Монгол Улсын иргэн өмчлүүлсэн газрыг зориулалтын дагуу ашиглах, бусдад шилжүүлэх, ашиглуулах харилцааг энэ хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай болон Иргэний хуулиар зохицуулна.

39 дүгээр зүйл.Төрийн өмчийн газрыг Монгол Улсын иргэний өмчлөлд шилжүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага

39.1.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын ангилалд хамаарах газраас Монгол Улсын иргэний өмчлөлд шилжүүлнэ.

39.2.Монгол Улсын иргэний өмчилсөн газар нь бусдад өмчлүүлсэн болон газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлсэн газартай давхцалгүй байна.

39.3.Дараах газраас газар өмчлөх эрхээр шилжүүлэхийг хориглоно:

39.3.1.газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын хот, тосгон бусад суурины эдэлбэр газраас бусад ангиллын газар;

39.3.2.бэлчээр болон нийтийн эдэлбэрийн газар;

39.3.3.тусгай хэрэгцээний газар;

39.3.4.түүх, соёлын дурсгалт болон соёлын өв бүхий газар.

39.4.Монгол Улсын иргэн өмчлөлийн газраа худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс, гадаад улсын хуулийн этгээдийн өмчлөлд шилжүүлж, аливаа хэлбэрээр ашиглуулахыг хориглоно.

40 дүгээр зүйл.Газар өмчлөх зориулалт, хэмжээ

40.1.Монгол Улсын иргэнд амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлэх газар нь байршлаасаа хамаарч дараах хэмжээтэй байна:

- 40.1.1.нийслэлд 0.07 хүртэл га;
- 40.1.2.аймгийн төвд 0.35 хүртэл га;
- 40.1.3.сумын төв, тосгонд 0.5 хүртэл га.

40.2.Тухайн орон нутгийн газрын нөөц, багтаамж, хүн амын тоо, нийгэм, эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн тухайн орон нутагт өмчлүүлэх газрын дээд хэмжээг энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан хэмжээнд багтаан аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

40.3.Амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтыг газар ашиглалтын бүсчлэлийн дүрэмд нийцүүлэн өөрчилж болно.

40.4.Монгол Улсын иргэн нь өмчилсөн газрын зориулалт өөрчлөх хүсэлтээ аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

40.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 40.3-т заасан газар ашиглалтын бүсчлэлийн дүрэмд нийцэж байвал өмчилсөн газрын зориулалт өөрчлөх шийдвэр гаргана.

41 дүгээр зүйл.Төрийн өмчийн газрыг Монгол Улсын иргэнд өмчлөх эрхээр шилжүүлэх

41.1.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд Монгол Улсын иргэнд өмчлүүлэхээр тусгасан газраас энэ хуулийн 40.1-д заасан хэмжээгээр газрыг нэг удаа үнэгүй өмчлөх эрхээр шилжүүлж болно.

41.2.Монгол Улсын иргэн нь амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалттай барилга байгууламж барих газрын эрхээр шилжүүлэн авсан газраа газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар ашиглалтын бүсчлэлийн дүрэмд нийцэж байгаа тохиолдолд энэ хуулийн 41.1-д заасны дагуу өмчлөх эрхээр шилжүүлэн авч болно.

41.3.Энэ хуулийн 41.2-т заасан тохиолдолд улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг харгалзахгүй.

42 дугаар зүйл.Монгол Улсын иргэн өмчлөлийн газраа бусдад шилжүүлэх

42.1.Монгол Улсын иргэн өмчилсөн газраа дараах байдлаар иргэн, хуулийн этгээдэд шилжүүлж болно.

- 42.1.1.Монгол Улсын иргэнд газар өмчлөх эрхээр;

42.1.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламж барих газрын эрхээр.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасан эрхээр шилжүүлэхдээ гэрээний үндсэн дээр, эсхүл газрын биржээр дамжуулан дуудлага худалдааны журмаар шилжүүлнэ.

42.3.Энэ хуулийн 42.2-д заасны дагуу бусдад шилжүүлсэн тохиолдолд иргэний тухайн газрын өмчлөх эрх дуусгавар болно.

42.4.Энэ хуулийн 42.1.2-т заасны дагуу бусдад шилжүүлж байгаа тохиолдолд харьяалах аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргана.

42.5.Энэ хуулийн 42.4-т заасан хүсэлтийг хүлээн авч иргэний өмчлөх эрхийг дуусгавар болгож, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламж барих газрын эрхээр шилжүүлэх шийдвэр гаргана.

43 дугаар зүйл.Иргэн өмчийн газраа бусдад ашиглуулах

43.1.Иргэн өмчлөлийн газраа зориулалтаар нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

43.2.Иргэн өмчлөлийн газраа бусдад ашиглуулахдаа дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчид мэдэгдэнэ.

44 дүгээр зүйл.Газар өмчлөх эрхийн зохицуулалт

44.1.Монгол Улсын иргэн газар өмчлөх эрхийн хүсэлт гаргах, өмчлүүлэх шийдвэр гаргах, өмчлөх эрхийг дуусгавар болгох, иргэн өмчилсөн газраа бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, газраа бусдад гэрээгээр ашиглуулахтай холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ, ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

45 дугаар зүйл.Төрийн өмчийн газрыг бусдад шилжүүлэх төрөл

45.1.Төрийн өмчийн газрыг тодорхой нөхцөл, болзол, хугацаатайгаар Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн, Монгол Улсын хуулийн этгээдэд дараах газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлж болно:

45.1.1.газрын узифрукт эрх;

45.1.2.барилга байгууламж барих газрын эрх.

45.2.Нийтийн зориулалттай орон сууц болон олон өмчлөгчтэй барилга байгууламжийн доорх болон орчны газрыг өмчлөгчдөд дундын мэдлийн газрын эрхээр шилжүүлнэ.

45.3. Газрын узифрукт эрхийг Монгол Улсын хуулийн этгээдэд шилжүүлэх заалт нь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд хамаарахгүй.

46 дугаар зүйл. Газрын хязгаарлагдмал эрхийн зориулалт

46.1.Газрын үр шимийг хүртэх, ашиг олох зорилгоор хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар газрыг узуфрукт эрхээр олгоно.

46.2.Газрын гадаргуу дээр болон доор барилга байгууламж барих, уг барилга байгууламжийг ашиглах зориулалтаар газрыг барилга байгууламж барих газрын эрхээр олгоно.

46.3.Энэ хуулийн 46.1, 46.2-т заасан газрын хязгаарлагдмал эрхээр иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх газар ашиглалтын зориулалт, түүнийг өөрчлөх журмыг Засгийн газар батална.

47 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх газрын хэмжээ

47.1.Газрын хязгаарлагдмал эрхээр Монгол Улсын иргэнд газрыг дараах хэмжээгээр нэг удаа үнэгүй шилжүүлж болно.

47.1.1.газрын узуфрукт эрхээр төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0.1 га-гаас илүүгүй;

47.1.2.барилга байгууламж барих газрын эрхийг амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтаар энэ хуулийн 40.1-д заасан хэмжээгээр;

47.1.3.барилга байгууламж барих газрын эрхийг өвөлжөө, хаваржааны барилга байгууламж барих зориулалтаар 1.0 га-аас илүүгүй.

47.2.Энэ хуулийн 47.1-д зааснаас бусад тохиолдолд газрын хязгаарлагдмал эрхээр олгох газрын хэмжээг улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд заасны дагуу тогтооно.

47.3.Газрын узуфрукт эрхээр нэг иргэн, хуулийн этгээд түүний эцсийн өмчлөгчид олгох газрын дээд хэмжээг Засгийн газар тогтооно.

47.4.Энэ хуулийн 47.1-47.3-т заасан газрын хэмжээнд газрын мэдээллийн системээр дамжуулан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авна.

48 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа

48.1.Газрын хязгаарлагдмал эрхийг 33 жилийн хугацаагаар олгоно.

48.2.Газрын узуфрукт эрхтэй этгээд газраа зориулалтын дагуу ашиглаж байгаа бол хугацааг олгосон хугацаагаар сунгаж болно.

48.3.Барилга байгууламж барих газрын эрхийн хугацааг олгосон хугацаагаар сунгаж болох бөгөөд нийт хугацаа нь Иргэний хуулийн 150.3-т заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

48.4.Газрын хязгаарлагдмал эрхийн хугацааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

48.5.Газрын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа нь энэ хуулийн 48.1-48.3-т заасан хугацааны үлдсэн хугацаатай адил байна.

49 дүгээр зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээ

49.1.Газрын хязгаарлагдмал эрх нь гэрчилгээтэй байна.

49.2.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээ дээр газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэн авсан иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, тэдгээрийн регистрийн дугаар, эрхийн төрөл, эрх олгосон шийдвэрийн огноо, дугаар, газрын хэмжээ, байршил, зориулалт, эрхийн хугацаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дугаар болон шийдвэр гаргасан албан тушаалтны овог, нэрийг тусгасан байна.

49.3.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээ тухайн газрын талаарх мэдээллийг агуулсан дахин давтагдашгүй дугаар бүхий код болон бусад нууцлалтай байна.

49.4.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээний загварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

49.5.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээг хуурамчаар үйлдэх, хэвлэхийг хориглоно.

50 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхтэй этгээдийн эрх, үүрэг

50.1.Газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд дараах эрх эдэлнэ:

50.1.1.эрхээ бусдад шилжүүлэх, өвлүүлэх;

50.1.2.эрхээ бусдад ашиглуулах, барьцаалах;

50.1.3.газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол эрхийн хугацааг сунгуулах;

50.1.4.газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрыг чөлөөлөх шийдвэр гарсан бол хуульд заасан нөхөх олговор авах;

50.1.5.эрхээр шилжүүлэн авсан газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх.

50.2.Газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд дараах үүрэг хүлээнэ:

50.2.1.газрын төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн төлөх;

50.2.2.газрыг зориулалтын дагуу ашиглах;

50.2.3.газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх;

50.2.4.газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан бол учруулсан хохирлыг тогтоосон журмын дагуу нөхөн төлөх;

50.2.5.газрын хязгаарлагдмал эрхийг бусад барьцаалах, ашиглуулах тохиолдолд аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, эсхүл газрын мэдээллийн системээр дамжуулан бүртгүүлэх;

50.2.6.нийтийн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй

байх;

50.2.7.газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулж эргүүлэн авах шийдвэр гарч, гэрээ байгуулсан бол гэрээнд заасан хугацаанд газрыг чөлөөлөх;

50.2.8.газарт бэхэлсэн нэгж талбарын эргэлтийн цэгийг өөрчлөхгүй байх;

50.2.9.өөрийн нэгж талбарын эргэлтийн цэгээс гадна бусдын болон нийтийн эдэлбэрийн газарт газар ашиглахгүй байх;

50.2.10.газрыг гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлж, ашиглуулахгүй байх;

50.2.11.газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

50.2.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

51 дүгээр зүйл.Газрын хязгаарлагдмал эрхээр олгосон газрын төлбөр

51.1.Газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээд нь Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу газрын төлбөр төлнө.

51.2. Газрын хязгаарлагдмал эрхийг 2, түүнээс дээш этгээд дундаа хамтран шилжүүлэн авсан тохиолдолд газрын төлбөрийг талууд тохиролцсон хувь хэмжээгээр төлнө.

51.3.Газрын төлбөрийг газрын мэдээллийн системээр ногдуулна.

51.4.Газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөртэй холбоотой харилцааг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

52 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх

52.1.Газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээд нь бичгээр байгуулсан гэрээ, эсхүл газрын биржээр дамжуулан эрхээ бусдад шилжүүлж болно.

52.2.Газрын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх гэрээг нотариатаар баталгаажуулж, хүсэлтийн хамт дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчид төрийн үйлчилгээний нэгдсэн төв, газрын мэдээллийн системээр дамжуулан, эсхүл цаасаар гаргана.

52.3.Газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн нас барсан тохиолдолд газрын хязгаарлагдмал эрхийг өвлүүлэхэд Иргэний хуульд заасан журмыг баримтална. Өв залгамжлагч нь эрх шилжүүлэн авах хүсэлтээ энэ хуулийн 52.2-т заасан байгууллага, албан хаагчид гаргана.

52.4.Энэ хуулийн 52.2, 52.3-т заасны дагуу газрын хязгаарлагдмал эрхээ бусдаас шилжүүлэн авсан тохиолдолд газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа нь энэ хуулийн 48.1-48.3-т заасан хугацааны үлдсэн хугацаатай адил байна.

52.5.Газрын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх, эрхийн хугацааг сунгах, эрх дуусгавар болгох хүсэлтийг ажлын 15 өдрийн дотор шийдвэрлэнэ.

52.6.Газрын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх шийдвэр гаргах, газрын мэдээллийн системд бүртгэж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээг баталгаажуулах, нэгж талбарын хувийн хэрэг нээх, хадгалах, газрыг хүлээлгэн өгөх харилцааг Кадастрын тухай хуулиар зохицуулна.

53 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах, бусдад ашиглуулах

53.1.Газрын хязгаарлагдмал эрхийг энэ хуулийн 45.1-д заасан этгээдэд барьцаалж, ашиглуулж болно.

53.2.Газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах, ашиглуулах хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч, төрийн үйлчилгээний нэгдсэн төв, эсхүл газрын мэдээллийн системээр дамжуулан гаргана.

53.3.Дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч хүсэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авч, газрын мэдээллийн системд бүртгэнэ.

53.4.Газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалахад Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Иргэний хуулийг баримтална.

54 дүгээр зүйл.Газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болох

54.1.Дараах нөхцөлд газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болно:

54.1.1.газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дууссан;

54.1.2.газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээд эрхээсээ татгалзаж, дуусгавар болгох хүсэлт гаргасан;

54.1.3.газрын хязгаарлагдмал эрхээ бусдад шилжүүлсэн;

54.1.4.газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгосон, хүчингүй болгосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

54.1.5.газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон бөгөөд түүний өв залгамжлагч байхгүй нь тогтоогдсон;

54.1.6.газрын хязгаарлагдмал эрхтэй хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

54.1.7.тусгай хэрэгцээний газарт авахаар тохиролцож нөхөх олговор олгосон, эсхүл өөр газраар солихоор тохиролцож гэрээ байгуулсан;

54.1.8.нийтийн зориулалттай орон сууц болон барилга барьж байнгын ашиглалтанд хүлээлгэн өгч, дундын мэдлийн газрын эрхээр шилжүүлэх хүсэлт гаргасан;

54.1.9.газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн Монгол Улсын харьяатаас гарсан;

54.1.10.энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох шийдвэр гарсан.

54.2.Газрын хязгаарлагдмал эрхийг дуусгавар болгосон тухай шийдвэрийг тухайн эрх олгосон этгээд гаргаж, дундын мэдээллийн сангаар дамжуулан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд мэдэгдэнэ.

54.3.Барилга байгууламж барих газрын эрхтэй газарт баригдсан барилга байгууламжийн нурсан, эвдэрсэн нь уг эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

55 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох

55.1.Газрын хязгаарлагдмал эрх олгосон этгээд дараах тохиолдолд газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно:

55.1.1.энэ хуулийн 50.2-т заасан үүргээ хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн;

55.1.2.газрын төлбөрийн өр үүссэн хугацаанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн өрийг бүрэн төлөөгүй;

55.1.3.газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан, газрыг нөхөн сэргээх үүргээ зөрчсөн;

55.1.4.газрыг гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлсэн, ашиглуулсан;

55.1.5.газар дээрээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулсан;

55.1.6.өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад барьцаалж, ашиглуулсан.

55.2.Энэ хуулийн 55.1.3, 55.1.5-д заасныг зөрчсөн нь мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдсон, энэ хуулийн 55.1.4-т заасныг зөрчсөнийг холбогдох байгууллага тогтоосон бол газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно.

55.3.Энэ хуулийн 55.1-д заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргахаас өмнө газрын хязгаарлагдмал эрхтэй этгээдэд Захиргааны ерөнхий хуульд заасан хэлбэрээр, эсхүл газрын мэдээллийн системээр дамжуулан мэдэгдэнэ.

55.4.Газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгосон шийдвэрийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, газрын мэдээллийн системээр эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээнэ.

55.5.Энэ хуулийн 55.1-д заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгосон бол газар чөлөөлөхтэй холбоотой зардал, газарт учирсан хохирлыг газрын хязгаарлагдмал эрхтэй байсан этгээдээр нөхөн төлүүлнэ.

55.6.Газрын хязгаарлагдмал эрхийг энэ хуулийн 55.1.2-т заасан үндэслэлээр хүчингүй болгох шийдвэр гарсны дараа газрын төлбөрөө төлсөн нь газрын хязгаарлагдмал эрхийг сэргээх үндэслэл болохгүй.

55.7.Газрын хязгаарлагдмал эрхийг дуусгавар болгох, хүчингүй болгох тухай шийдвэрийн талаар газрын хязгаарлагдмал эрхтэй байсан этгээд болон барьцаалагч газрын маргаан таслах зөвлөл, эсхүл шүүхэд гомдол гаргасан бол маргаан таслах

зөвлөл болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гартал тухайн газрын хязгаарлагдмал эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

56 дугаар зүйл. Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дуусахаас өмнө газрыг өөр газраар солих, эсхүл эргүүлэн авах

56.1. Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дуусахаас өмнө Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн дагуу газрыг өөр газраар солих, эсхүл нөхөх олговортойгоор эргүүлэн авч болно.

56.2. Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дуусахаас өмнө улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд зориулан газрыг өөр газраар солих, эсхүл нөхөх олговортойгоор эргүүлэн авч болно.

56.3. Энэ хуулийн 56.2-т заасан үндэслэлээр газрыг өөр газраар солих болон эргүүлэн авах харилцааг энэ хуулийн 16.8-д заасан журмаар зохицуулна.

57 дугаар зүйл. Газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болоход газар чөлөөлөх

57.1. Иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болоход хуульд өөрөөр заагаагүй бол уг газрыг 45 хоногийн хугацаанд чөлөөлж, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.

57.2. Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дууссан, хүчингүй болсон тохиолдолд уг газарт салшгүй бэхлэгдсэн барилга байгууламжийг өмчлөх эрх нь төрд шилжинэ.

57.3. Энэ хуулийн 57.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар чөлөөлөх, албадан нүүлгэх журмын дагуу шийдвэрлэнэ.

57.4. Энэ хуулийн 57.3-т заасан үндэслэлээр газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газрын хязгаарлагдмал эрхтэй байсан этгээд хариуцна.

57.5. Газар чөлөөлөх, албадан нүүлгэх журам, хураагдсан эд хөрөнгийг түр хадгалах, буцаан олгох, улсын орлого болгох журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал батална.

58 дугаар зүйл. Дундын мэдлийн газрын эрх

58.1. Дундын мэдлийн газрын эрх нь дараах барилга байгууламжийн өмчлөгчдөд үүснэ:

58.1.1. хоёр, түүнээс дээш өмчлөгчтэй нийтийн зориулалттай орон сууц, талбай, дулаан зогсоол;

58.1.2. тодорхой зориулалтаар ашиглах хоёр, түүнээс дээш өмчлөгчтэй барилга, байгууламж.

58.2. Энэ хуулийн 58.1-д заасан дундын мэдлийн газрын эрх нь гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд болон барилгын түрээслэгч, ашиглагч нарт хамаарахгүй.

58.3.Дундын мэдлийн газрын эрхтэй барилгын өмчлөгч нар дундаа нэг эрхтэй байх бөгөөд уг эрх нь барилгын доорх болон орчны газрын нийт талбайн хэмжээгээр тодорхойлогдоно. Газрын хэмжээ нь бодит байдлаар хуваагдахгүй.

58.4.Дундын мэдлийн газрын эрхтэй барилгын өмчлөгчид ногдох газрын эрхийн хувь хэмжээг тогтоох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

58.5.Орчны газарт барилгын өмчлөгчдөд зориулагдсан ногоон байгууламж, зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, явган хүний зам, спортын талбай, авто зогсоол, ахуйн хог хаягдлын цэг бүхий нийтийн эдэлбэрийн газар хамаарна.

58.6.Дундын мэдлийн газрын эрхтэй өмчлөгчид орчны газрыг эрүүл ахуй, галын аюулгүй байдал, хот байгуулалт, барилгын болон бусад норм, дүрэмд нийцүүлэн нийтээр дундаа ашиглана.

58.7.Энэ хуулийн 58.6-д заасан газрыг өөр зориулалтаар ашиглах бол дундын мэдлийн газрын эрхтэй өмчлөгчдийн 75-аас дээш хувийн зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэнэ.

58.8.Дундын мэдлийн газрын эрх нь барилгын үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн салшгүй хэсэг бөгөөд дангаараа худалдах, худалдан авах, өв залгамжлах болон барьцааны зүйл болохгүй.

58.9.Дундын мэдлийн газрын эрх үүсэх этгээд байхгүй бол дундын мэдлийн газрын эрх төрд шилжинэ.

59 дүгээр зүйл.Дундын мэдлийн газрын хил зааг, хэмжээ

59.1.Энэ хуулийн 58.1-д заасан газрын хил зааг, хэмжээг тухайн хороолол, хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслөөр тодорхойлно.

59.2.Энэ хуулийн 58.1-д заасан газрын хил зааг нь тодорхойгүй байвал хөрш газрын хил заагийг үндэслэн тухайн барилга байгууламж барихад олгосон газар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл, хот байгуулалтын норм, дүрмийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

59.3.Дундын мэдлийн газар нь хил заагийг харуулсан нэгж талбарын кадастрын зурагтай байх бөгөөд өмчлөгч тус бүрт ногдох газрын хувь хэмжээг газрын мэдээллийн систем болон газрын кадастрын зурагт бүртгэнэ.

60 дугаар зүйл.Дундын мэдлийн газрын эрхийн хугацаа

60.1.Дундын мэдлийн газрын эрх нь энэ хуулийн 58.1-д заасан барилга байгууламжийн өмчлөх хугацаатай адил байна.

61 дүгээр зүйл.Дундын мэдлийн газрын эрх үүсэх, шилжүүлэх

61.1.Энэ хуулийн 58.1-д заасан барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан бол тухайн газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээд нь эрхээ дуусгавар

болгох, барилгын өмчлөгчдөд дундын мэдлийн газрын эрхээр шилжүүлэх хүсэлт гаргана.

61.2.Энэ хуулийн 61.1-д заасан хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын хязгаарлагдмал эрхийг дуусгавар болгож, барилгын өмчлөгчдөд дундын мэдлийн газрын эрхээр шилжүүлэх шийдвэр гаргана.

61.3.Энэ хуулийн 61.1-д заасан хүсэлт гаргаагүй нь барилгыг өмчлөгчдөд дундын мэдлийн газрын эрхийг шилжүүлэхэд саад болохгүй.

61.4.Энэ хуулийн 58.1-д заасан барилгын өмчлөгч нар үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авахад газрын мэдээллийн системээс дундын мэдлийн газрын эрх дагалдан үүснэ.

61.5.Дундын мэдлийн газрын эрх нь барилгын өмчлөх эрхийг дагалдан шилжинэ.

61.6.Энэ хуулийн 58.1-д заасан барилгын ашиглалтын хугацаа дууссан, эсхүл нурсан, эвдэрсэн нь дундын мэдлийн газрын эрх дуусгавар болохгүй бөгөөд барилгын өмчлөгчид хамтран тухайн газар дээр дахин барилга барих, эсхүл тухайн газрыг дуудлага худалдаанд оруулах тухай шийдвэрийг гаргана.

61.7.Дундын мэдлийн газрын эрхтэй этгээдийн энэ хуулийн 61.6-д заасан шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулах журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

62 дугаар зүйл.Дундын мэдлийн газрын эрх дуусгавар болох

62.1.Дундын мэдлийн газрын эрхийг дараах тохиолдолд дуусгавар болгоно:

62.1.1.дундын мэдлийн газрын эрхэд хамаарах барилгын өмчлөгч эрхээ бусдад шилжүүлсэн, өвлүүлсэн;

62.1.2.дундын мэдлийн газрын эрхэд хамаарах барилгын өмчлөгчид тухайн газрыг энэ хуулийн 61.6-д заасны дагуу газрын дуудлага худалдаагаар худалдсан;

62.1.3.дундын мэдлийн газрын эрхэд хамаарах барилгыг буулгах, дахин төлөвлөлтөд оруулахаар эрх бүхий байгууллага шийдвэрлэж, өмчлөгч нартай тохиролцож нөхөх олговор олгосон.

63 дугаар зүйл.Сервитут тогтоох

63.1.Эрх бүхий байгууллагаас олгосон газар өмчлөх, газрын хязгаарлагдмал эрх болон дундын мэдлийн газрын эрхээ хэрэгжүүлэх, хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусдын газрын эрхийг хязгаарлаж сервитут тогтоож болно.

63.2.Сервитут нь тодорхой нөхцөл, болзол, хугацаатай байх бөгөөд дараах төрөлтэй байна:

63.2.1.нийтийн;

63.2.2.хувийн.

63.3.Сервитутыг дараах зориулалтаар тогтоож болно:

63.3.1.дамжин өнгөрөх;

63.3.2.хил заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэгт тавих;

63.3.3.намагжилт, цөлжилтийг багасгах ажил гүйцэтгэх;

63.3.4.инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ байгуулах, ашиглах;

63.3.5.хайгуул судалгаа, ижил төстэй бусад үйл ажиллагаа явуулах;

63.3.6.усны сан болон ойн сангийн газарт байгалийн дагалт баялаг ашиглах, аялах.

63.4.Хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн нийтийн сервитут тогтооно.

63.5.Гамшиг, аюулт үзэгдлийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор нийтийн сервитутыг Засгийн газар тогтоож болно.

63.6.Энэ хуулийн 63.4, 63.5-д зааснаас бусад тохиолдолд нийтийн сервитут тогтоохыг хориглоно.

63.7.Энэ хуулийн 63.4-т заасан нийтийн сервитут тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хоёр, түүнээс дээш аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийг хамарсан нийтийн сервитут тогтоох асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

63.8.Нийтийн сервитут тогтооход эрх нь хязгаарлагдаж байгаа газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал болон дундын мэдлийн газрын эрхтэй этгээдэд мэдэгдэж нийтийн сервитут тогтоох шийдвэрийг энэ хуулийн 63.7-д заасан байгууллага гарган газрын мэдээллийн системд бүртгэнэ.

63.9.Сервитут тогтоолгуулсан этгээд газар өмчлөх, газрын хязгаарлагдмал болон дундын мэдлийн газрын эрхтэй этгээдийн аливаа үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

63.10.Нийтийн болон хувийн сервитут тогтоох болон дуусгавар болгох шийдвэрийг газрын мэдээллийн системд бүртгэнэ.

63.11.Газар өмчлөх, газрын хязгаарлагдмал болон дундын мэдлийн газрын эрхтэй этгээдүүд хоорондоо хувийн сервитут тогтоох гэрээ байгуулан бүртгүүлэх хүсэлтээ сервитут тогтоосон газрын хил заагийг кадастрын зургийн хамт аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

63.12.Энэ хуулийн 63.11-д заасан хүсэлтийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч, газрын мэдээллийн системд бүртгэнэ.

63.13.Хувийн сервитуттай холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

64 дүгээр зүйл.Сервитутын хугацаа

64.1.Сервитут нь байнгын, эсхүл түр хугацаатай байна.

64.2.Энэ хуулийн 63.5-д заасан зорилгоор нийтийн сервитутыг тухайн нөхцөл, байдал арилтал түр хугацаагаар тогтооно.

64.3.Хүн, хуулийн этгээдийн хооронд байгуулсан хувийн сервитутын хугацааг гэрээгээр тогтооно.

64.4.Энэ хуулийн 63.3.4-т заасан зориулалтаар нийтийн сервитут тогтоосон бол тэдгээрийн байнгын ашиглалтын хугацаагаар тогтооно.

65 дугаар зүйл.Сервитут тогтоолгосон этгээдийн эрх

65.1.Сервитут тогтоолгосон этгээд дараах эрх эдэлнэ:

65.1.1.нийтийн сервитут тогтоосноос болж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд тухайн нутаг дэвсгэрийн маргаан таслах зөвлөл, эсхүл шүүхэд хандаж эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах;

65.1.2.нийтийн сервитут тогтоосноос газраа ашиглах боломжгүй буюу ашиглахад хүндрэл бэрхшээлтэй болсон тохиолдолд уг газрыг худалдан авах, мөн түүнд учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ БУСДАД АШИГЛУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

66 дугаар зүйл.Төрийн өмчийн газрыг бусдад ашиглуулах

66.1.Төрийн өмчийн газрыг энэ хуульд заасан зориулалт, үндэслэл, зөвшөөрөл, журмын дагуу дараах этгээдэд гэрээгээр ашиглуулж болно:

66.1.1.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд;

66.1.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

66.1.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээд;

66.1.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газар.

66.2.Төрийн өмчийн газрыг гэрээгээр ашиглуулахдаа үнэтэй, эсхүл үнэгүйгээр ашиглуулна.

66.3.Төрийн өмчийн газрыг гэрээгээр бусдад ашиглуулах журмыг Засгийн газар батална.

66.4.Чөлөөт бүс болон тусгай хамгаалалттай газар нутагт хүн, хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулахдаа дуудлага худалдааны журмыг баримтална.

66.5.Газрыг гэрээгээр ашиглаж байгаа этгээд газраа бусдад шилжүүлэх, барьцаалах, захиран зарцуулахыг хориглоно.

67 дугаар зүйл.Төрийн өмчийн газрыг бусдад ашиглуулах шийдвэр гаргах, гэрээ байгуулах

67.1.Дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан дор дурдсан үндэслэлээр газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргана:

67.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, газар ашиглах хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

67.1.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, газар ашиглах хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

67.1.3.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

67.1.4.чөлөөт бүсэд газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, улсын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн дуудлага худалдааны ялагчид чөлөөт бүсийн захирагч;

67.1.5.улсын тусгай хамгаалалттай газар нутагт газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн дуудлага худалдааны ялагчид байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

67.1.6.улсын тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

67.1.7.энэ хуулийн 67.1.4, 67.1.5, 67.1.6-д зааснаас бусад тусгай хэрэгцээний газарт газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

67.1.8.аймаг, сумын чанартай отрын нөөц нутагт газар ашиглуулах шийдвэрийг тухайн шатны Засаг дарга;

67.1.9.аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд ойжуулахаар төлөвлөгдсөн байршилд мод тарих, үржүүлэх, ойжуулах зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

67.2.Энэ хуулийн 67.1.1-67.1.3, 67.1.6-67.1.9-д заасан газрыг гэрээгээр ашиглах хүн, хуулийн этгээд, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газар /цаашид "газар ашиглагч этгээд" гэх/-т газар ашиглуулах шийдвэрийг ажлын 15 өдөрт багтаан гаргана.

67.3.Энэ хуулийн энэ хуулийн 67.1.4, 67.1.5-д заасан газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг дуудлага худалдааны ялагч шалгарсанаас хойш ажлын 15 өдөрт багтаан гаргана.

67.4.Газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрт газрыг гэрээгээр ашиглах хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, регистрын дугаар, зориулалт, хугацаа, газрын хэмжээ, байршил, хил заагийг тусгасан байна.

67.5.Газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг газрын мэдээллийн системд бүртгэж, гэрээ байгуулах, нэгж талбарын хувийн хэрэг нээх, хадгалах, газрыг хүлээлгэн өгөх харилцааг Кадастрын тухай хуулиар зохицуулна.

67.6.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчийн газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах, гэрээг бүртгэхэд хяналт тавина.

67.7.Газар ашиглагч этгээд нь газар болон гэрээгээ бусдад шилжүүлэх, барьцаалахыг хориглоно.

67.8.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэх, хадлан хадах, зам гүүр, эрчим хүч, харилцаа холбооны шугам байгуулах, засварлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх, байгалийн аялал хийх, түр буудаллах, отоглохоос бусад зориулалтаар газрыг ашиглуулахыг хориглоно.

68 дугаар зүйл.Газар ашиглуулах гэрээ

68.1.Газар ашиглуулах гэрээ нь газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

68.2.Газар ашиглуулах гэрээнд дараах зүйлийг тусгана:

68.2.1.газар ашиглагч хүн, хуулийн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, регистрын дугаар;

68.2.2.газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийн огноо, дугаар;

68.2.3.зориулалт, хэмжээ;

68.2.4.газрын нэгж талбарын дугаар, хаяг;

68.2.5.газар ашиглуулах гэрээний хугацаа;

68.2.6.газрын төлбөр төлөх үүрэг;

68.2.7.гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага;

68.2.8.газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажил;

68.2.9.гэрээг цуцлах үндэслэл;

68.2.10.бусад зүйл.

68.3.Газар ашиглуулах гэрээ нь энэ хуулийн 68.2-т заасан мэдээллийг багтаасан дахин давтагдахгүй дугаар бүхий код болон бусад нууцлалтай байна.

68.4.Газар ашиглуулах гэрээний загварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

68.5.Газар ашиглуулах гэрээний үүргийн хэрэгжилтийг 2 жил тутамд дүгнэнэ.

69 дүгээр зүйл.Газар ашиглуулах гэрээний хугацаа

69.1.Газар ашиглуулах гэрээ нь хугацаатай, эсхүл хугацаагүй байна.

69.2.Газар ашиглагч этгээд газар ашиглуулах гэрээний хугацааг сунгах тухай хүсэлтээ гэрээний үндсэн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө газрын мэдээллийн

системээр дамжуулан газар ашиглуулах шийдвэр гаргасан этгээдэд гаргана.

69.3.Газар ашиглагч этгээд газар ашиглуулах гэрээний хугацааг өмнөх хугацаатай адил хугацаагаар сунгаж болно.

70 дугаар зүйл.Гэрээгээр ашиглуулж буй газрын төлбөр

70.1.Төрийн өмчийн газар ашиглагч этгээд нь газрын төлбөр төлнө.

70.2.Газрыг 2, түүнээс дээш этгээд дундаа хамтран ашиглахаар гэрээ байгуулсан тохиолдолд газрын төлбөрийг талууд тохиролцсон хувь хэмжээгээр төлнө.

70.3.Газрын төлбөрийг газрын мэдээллийн системээр ногдуулна.

70.4.Газрын төлбөртэй холбоотой харилцааг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

71 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд газар ашиглуулах

71.1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүждэг төрийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай газраа гэрээгээр ашиглах хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч, үйлчилгээний нэгдсэн төв, газрын мэдээллийн цахим системээр дамжуулан, эсхүл цаасаар гаргана.

71.2.Энэ хуулийн 71.1-д заасан хүсэлтийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч энэ хуулийн 67.1.1-д заасны дагуу газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.

71.3.Энэ хуулийн 71.2-т заасан газар ашиглуулах гэрээг хугацаагүй байгуулах бөгөөд тухайн байгууллагыг өөрчлөх, татан буугдахад газар ашиглуулах гэрээ дуусгавар болно.

72 дугаар зүйл.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээдэд газар ашиглуулах

72.1.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй хэрэгцээтэй газрыг дор дурдсан журмаар шийдвэрлэж, газрыг гэрээгээр ашиглуулж болно:

72.1.1.энэ хуулийн 16.1.4-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газарт газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргаж, газар ашиглуулах гэрээ байгуулна;

72.1.2.газар ашиглуулах нөхцөл, болзол, журмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтооно.

72.1.3.газар ашиглуулах гэрээний хугацаа болон төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтална.

72.1.4.энэ хуулийн 72.1.3-т зааснаас бусад тохиолдолд газар ашиглуулах гэрээг 33 жилийн хугацаатай байгуулах бөгөөд гэрээний хугацааг анх гэрээ байгуулсан хугацаатай адил хугацаагаар сунгаж болно.

72.2.Гадаад улсын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газарт тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр газрыг ашиглуулж болно. Гэрээ байгуулах шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

72.3.Энэ хуулийн 72.2-т заасан шийдвэрт газрыг ашиглуулах зориулалт, хугацаа, төлбөрийг тодорхой заана.

73 дугаар зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах

73.1.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд амины орон сууцны байшин, гэр, сууц барих зориулалтаар 0.05 га-аас илүүгүй газрыг гэрээгээр үнэтэй ашиглуулж болно.

73.2.Энэ хуулийн 73.1-д заасан газар ашиглуулах гэрээг 5 жилийн хугацаатай байгуулах бөгөөд гэрээний хугацааг гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгаж болно.

74 дүгээр зүйл.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах

74.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн этгээдэд ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг тусгай зөвшөөрөл олгосноос хойш 1 хоногийн дотор энэ хуулийн 27.6-д заасан Газрын мэдээллийн системийн дундын мэдээллийн санд илгээнэ.

74.2.Энэ хуулийн 74.1-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргаж, газар ашиглуулах гэрээ байгуулна.

74.3.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй дараах зориулалтаар газрыг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэрээгээр ашиглуулж болно.

74.3.1.ажилчдын байнгын болон түр орон сууцны;

74.3.2.боловсруулах болон баяжуулах үйлдвэрийн;

74.3.3.зам, шугам сүлжээ, тэдгээрийн барилга байгууламжийн.

74.4.Энэ хуулийн 74.3-т заасны дагуу гэрээгээр ашиглуулах газар нь ашигт малтмал ашиглахтай холбогдуулан барилга байгууламж барих, зам, шугам сүлжээ татах үйл ажиллагаа явуулахад шаардагдах хэмжээнээс илүүгүй байна.

74.5.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах зориулалтаар газар ашиглагч этгээд нь Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу газрын төлбөр төлнө.

74.6.Ашигт малтмал, газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах газар ашиглуулах гэрээ нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаатай адил байна. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан нь газар ашиглуулах гэрээг сунгах үндэслэл болно.

74.7.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон газар нь иргэний газар өмчлөх эрх, хүн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулах газартай давхацсан тохиолдолд газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, уурхайн үйл ажиллагаанд саад учруулахааргүй нөхцөлд тодорхой нөхцөл, болзолтойгоор газар өмчлөх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулах асуудлыг цаашид үргэлжлүүлэх, эсэх талаар аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдтэй хэлэлцэж тохиролцсон байна.

74.8.Энэ хуулийн 74.7-д заасан нөхөх олговортойгоор чөлөөлөх газрын хэмжээ, зардал, нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд цаашид газар өмчлөх, хязгаарлагдмал эрхээр газраа үргэлжүүлэн ашиглах иргэн, хуулийн этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, болзлыг газар ашиглах гэрээнд тусгана.

74.9.Энэ хуулийн 74.7-д заасан нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрэн хариуцна.

74.10.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах зориулалтаар гэрээгээр ашиглаж байгаа газарт хүн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр газар ашиглуулахыг хориглоно.

75 дугаар зүйл. Чөлөөт бүсэд газар ашиглуулах

75.1.Чөлөөт бүсэд газар ашиглуулах асуудлыг чөлөөт бүсийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн зохион байгуулсан дуудлага худалдааны ялагчид газрын мэдээллийн системээр дамжуулан Чөлөөт бүсийн захирагч шийдвэрлэнэ.

75.2.Энэ хуулийн 75.1-д заасан газар ашиглуулах гэрээг 33 жилийн хугацаатай байгуулах бөгөөд уг гэрээний хугацааг анх гэрээ байгуулсан хугацаагаар сунгаж болно.

75.3. Чөлөөт бүсэд газар ашиглагч этгээд нь Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу газрын төлбөр төлнө.

76 дугаар зүйл. Газар ашиглуулах гэрээг дуусгавар болгох

76.1.Дараах нөхцөлд газар ашиглуулах гэрээ дуусгавар болно:

76.1.1.газар ашиглуулах гэрээний хугацаа дууссан;

76.1.2.газар ашиглагч этгээд гэрээг дуусгавар болгох хүсэлт гаргасан;

76.1.3.газар ашиглуулах гэрээг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

76.1.4.газар ашиглагч хүн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон бол;

76.1.5.газар ашиглагч хуулийн этгээд татан буугдсан, дамбуурсан;

76.1.6.тусгай хэрэгцээнд авахаар тохиролцож нөхөх олговор олгосон, эсхүл өөр газраар солихоор тохиролцож гэрээ байгуулсан;

76.1.7.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн газрыг чөлөөлөхөөр шийдвэрлэсэн;

76.1.8.энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан үндэслэлээр газар ашиглуулах гэрээг цуцалж, хүчингүй болгох шийдвэр гарсан.

76.2.Газар ашиглуулах гэрээг дуусгавар болгох шийдвэрийг тухайн гэрээ байгуулах шийдвэр гаргасан этгээд гаргаж, газар ашиглагч хүн, хуулийн этгээдэд ажлын 5 өдрийн дотор газрын мэдээллийн системээр мэдэгдэнэ.

77 дугаар зүйл. Газар ашиглуулах гэрээг цуцалж, хүчингүй болгох

77.1.Газар ашиглуулах гэрээг дараах үндэслэлээр цуцалж, хүчингүй болгох шийдвэр гаргана:

77.1.1.газар ашиглуулах гэрээний үүргээ хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн;

77.1.2.бусдад дамжуулан ашиглуулсан;

77.1.3.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барьсан, барих үйл ажиллагааг эхлүүлсэн;

77.1.4.газрын төлбөрийн өр үүссэн хугацаанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн өрийг бүрэн төлөөгүй;

77.1.5.хүн амын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагааг газар дээрээ явуулсан;

77.1.6.газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан, газрыг нөхөн сэргээх үүргээ зөрчсөн;

77.1.7.газрыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс, гадаадын улсын хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлсэн, ашиглуулсан.

77.2.Газар ашиглуулах гэрээг энэ хуулийн 77.1.4-т заасан үндэслэлээр хүчингүй болгох шийдвэр гарсны дараа газрын төлбөр төлсөн нь гэрээг дахин байгуулах үндэслэл болохгүй.

78 дугаар зүйл. Газар чөлөөлөх, нөхөн сэргээх

78.1.Газар ашиглуулах гэрээ дуусгавар болоход газар ашиглагч этгээд газрыг 45 хоногийн хугацаанд чөлөөлж ашиглахаас өмнөх төлөв байдалд нь сэргээн газар ашиглуулах шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

78.2.Энэ хуулийн 77.1.3-т заасан үндэслэлээр газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг хүчингүй болгосон бол гэм буруутай этгээд барилга байгууламжийг өөрийн зардлаар буулгах, эсхүл нүүлгэн шилжүүлж газрыг чөлөөлөх, өмнөх төлөв байдалд сэргээн оруулж, учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

78.3.Газар ашиглуулах гэрээ дуусгавар болоход уг газарт салшгүй бэхлэгдсэн барилга байгууламжийг өмчлөх эрх нь төрд шилжинэ.

78.4.Энэ хуулийн 78.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол энэ хуулийн 57.5-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

78.5.Энэ хуулийн 78.4-т заасан үндэслэлээр газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газар ашиглаж байсан этгээд хариуцна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ХЯЗГААРЛАГДМАЛ ЭРХ ОЛГОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГАЗРЫН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

79 дүгээр зүйл.Газрын хязгаарлагдмал эрх олгох, гэрээгээр ашиглуулах хэлбэр

79.1.Газрын хязгаарлагдмал эрх олгох болон газрыг гэрээгээр ашиглуулахдаа дараах аргыг хэрэглэнэ:

- 79.1.1.хүсэлтээр;
- 79.1.2.дуудлага худалдааны анхны үнээр;
- 79.1.3.төсөл сонгон шалгаруулалтаар;
- 79.1.4.дуудлага худалдаагаар.

79.2.Энэ хуулийн 79.1-д заасны дагуу газрын хязгаарлагдмал эрхээр болон газрыг гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, олгох арга нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.

80 дугаар зүйл.Газрыг хүсэлтийн дагуу шилжүүлэх

80.1.Монгол Улсын иргэн энэ хуулийн 47.1-д заасан газрын хязгаарлагдмал эрхийн аль нэгийг хүсэлт гаргаж нэг удаа үнэгүй шилжүүлэн авч болно.

80.2.Монгол Улсын иргэн 80.1-д заасан хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч, төрийн үйлчилгээний нэгдсэн төв, газрын мэдээллийн системээр дамжуулан, эсхүл цаасаар гаргана.

80.3.Иргэний гаргасан хүсэлтийг ирсэн дарааллын дагуу газрын мэдээллийн системд бүртгэж, мэдээллийн сан үүсгэнэ.

80.4.Энэ хуулийн 80.2-т заасан хүсэлт нь газрын мэдээллийн системд шийдвэрлэгдэх хүртэл хугацаагаар хадгалагдана. Иргэн мэдээллийн системд байршсан хүсэлтээсээ татгалзаж, өөрчилж болно.

80.5.Энэ хуулийн 80.2-т заасан хүсэлтийн шийдвэрлэлтийн явц, дарааллын талаарх мэдээллийг тухайн иргэнд газрын мэдээллийн системээр тухай бүр мэдээлнэ.

80.6.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд иргэнд үнэгүй олгохоор төлөвлөсөн нийт нэгж талбарын 10-аас доошгүй хувийг зорилтот бүлгийн иргэдэд тэргүүн ээлжинд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлнэ.

80.7.Энэ хуулийн 80.6-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 80.3-т заасан хүсэлтийн дарааллын дагуу хянаж, газрын хязгаарлагдмал эрх олгох эсэх шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

80.8.Өрхийн гишүүд нь өмчлөлийн орон сууцгүй, газар өмчлөх болон газрын хязгаарлагдмал эрхээ эдлээгүй дор дурдсан Монгол Улсын иргэнийг зорилтот бүлэгт хамааруулна:

- 80.8.1.35 хүртэлх насны залуу гэр бүлийн гишүүн;
- 80.8.2.0-18 насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй эцэг, эх;
- 80.8.3.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан;
- 80.8.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжилдаг иргэн;
- 80.8.5.гамшигт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон иргэн;
- 80.8.6.нийслэлээс хөдөө, орон нутагт шилжин суурьшсан иргэн.

80.9.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд туссан, иргэдэд газар өмчлөл болон газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлээгүй газарт энэ хуулийн 80.2-т заасан хүсэлт гаргасан иргэнд дарааллын дагуу хянаж, газрын хязгаарлагдмал эрх олгох эсэх шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

80.10.Энэ хуулийн 71.1, 72.1-д заасан төрийн байгууллага, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй хэрэгцээтэй газрыг хүсэлтээр олгоно.

80.11.Мод тарих, үржүүлэх, ойжуулах зориулалтаар Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулах газрыг хүсэлтээр олгоно.

80.12.Энэ хуулийн 80.11-д заасан зориулалтаар олгох газрын хэмжээ нь 5 га-гаас ихгүй, 10 жилийн хугацаатай байх бөгөөд хугацааг анх олгосон хугацаагаар сунгаж болно.

81 дүгээр зүйл. Дуудлага худалдааны анхны үнээр газрыг гэрээгээр ашиглуулах

81.1.Хүн, хуулийн этгээдэд 73.1, 74.3-д заасан газрыг гэрээгээр ашиглуулахдаа газрын дуудлага худалдааны анхны үнээр олгоно.

81.2.Энэ хуулийн 82.1-д заасан төсөл сонгон шалгаруулалтын ялагч болсон этгээд тухайн газрын дуудлага худалдааны анхны үнийг төлнө.

81.3.Газрын дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

82 дугаар зүйл. Төсөл сонгон шалгаруулалтаар газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглуулах

82.1.Тэргүүлэх чиглэлийн үйлдвэр, бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээ, орон сууцны хотхон, хороолол барихад зориулж төрийн өмчийн газрыг төсөл сонгон шалгаруулалтын аргаар газрын хязгаарлагдмал эрхээр болон гэрээгээр ашиглуулж болно.

82.2.Энэ хуулийн 82.1-д заасан төсөл сонгон шалгаруулалтаар газрын хязгаарлагдмал эрхээр болон гэрээгээр ашиглуулах газрыг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгана.

82.3.Төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

82.4.Энэ хуулийн 82.1-д заасан төсөл сонгон шалгаруулалтыг газрын биржээр дамжуулан зохион байгуулна.

82.5.Төсөл сонгон шалгаруулалтын ялагч нь тухайн газрын дуудлага худалдааны анхны үнийг төлнө.

83 дугаар зүйл.Дуудлага худалдаагаар газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглуулах

83.1.Энэ хуулийн 80-82 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглуулахдаа дуудлага худалдаагаар олгоно.

83.2.Газрын дуудлага худалдааны журмыг Засгийн газар батална.

83.3.Дуудлага худалдааг зөвхөн газрын биржээр зохион байгуулна.

84 дүгээр зүйл.Газрын бирж

84.1.Газрын биржийн үйл ажиллагааг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлж, улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

84.2.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын биржийн үйл ажиллагааг эрхлэх нэгжтэй байна.

84.3.Газрын биржийн үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

84.4.Газрын бирж /цаашид "бирж" гэх/-ийн үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, хараат бус байна.

84.5.Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах програм хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.

84.6.Биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, биржийн арилжааг хөгжүүлэх, биржийн үйл ажиллагааны чиглэлээр салбаруудын уялдааг хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдах зөвлөл ажиллана.

84.7.Удирдах зөвлөл нь холбогдох төрийн байгууллагууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын төлөөлөл болон бусад гишүүдээс бүрдэнэ.

84.8.Удирдах зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

84.9.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Чөлөөт бүсийн захирагч холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд газрыг гэрээгээр ашиглуулахтай холбоотой үйл ажиллагааг биржээр дамжуулан хэрэгжүүлнэ.

85 дугаар зүйл.Биржийн чиг үүрэг

85.1.Бирж нь энэ хуулийн 27.2.3-т заасан системийг ашиглан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

85.1.1.газрын дуудлага худалдааг зохион байгуулах;

85.1.2.төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

85.1.3.Монгол Улсын иргэн өмчилсөн газраа дуудлага худалдаагаар арилжихад зуучлах;

85.1.4.иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхийг дуудлага худалдаагаар арилжихад зуучлах;

85.1.5.газрын зах зээлийн үнийн мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд газрын үнэ, ханшийн мэдээллээр үйлчлэх, лавлагаа олгох;

85.1.6.газрын үр өгөөжийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах;

85.1.7.хууль болон журмаар хүлээсэн бусад чиг үүрэг.

86 дугаар зүйл.Биржийн үйл ажиллагааны орлого

86.1.Биржийн үйл ажиллагааны орлого нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

86.1.1.энэ хуулийн 85.1.1-85.1.4-т заасан орлого;

86.1.2.хүчингүй болсон дуудлага худалдааны дэнчин;

86.1.3.үйлчилгээний хураамж;

86.1.4.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

86.2.Энэ хуулийн 86.1-д заасан орлогын 70 хувийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дор дурдсан үйл ажиллагаанд зарцуулна:

86.2.1.газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх;

86.2.2.төрийн өмчийн газрын тооллого хийх;

86.2.3.газрын хянан баталгаа болон газрын мониторингийн хоёрдугаар зэрэглэлийн цэг дээр хэмжилт, судалгаа, шинжилгээний ажил хийх;

86.2.4.газар хөгжүүлэх;

86.2.5.газар чөлөөлөлттэй холбоотой нөхөх олговрын зардал;

86.2.6. иргэнд өмчлүүлсэн, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлсэн болон гэрээгээр ашиглуулсанаас бусад газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ.

86.3.Энэ хуулийн 86.1-д заасан орлогын 30 хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дор дурдсан үйл ажиллагаанд зарцуулна:

86.3.1.газрын мэдээллийн системийн үйл ажиллагаа, хөгжүүлэлт;
86.3.2.улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн
төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх;

86.3.3.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалт хийх;
86.3.4.газрын мониторингийн нэгдүгээр зэрэглэлийн цэг дээр хэмжилт,
судалгаа, шинжилгээний ажил хийх;

86.3.5.салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх, сургах;
86.3.6.газрын харилцааны салбарын хууль тогтоомж, журам, заавар,
норм, нормативын баримт бичиг, дүрэм, стандартыг шинэчлэн боловсруулах,
батлуулах.

НАЙМДУГААР БҮЛЭГ КАДАСТР

87 дугаар зүйл.Кадастрын төрөл, түүний агуулга

87.1.Кадастр нь дараах төрөлтэй байна:

- 87.1.1.нөөцийн кадастр;
- 87.1.2.эрхийн кадастр;
- 87.1.3.санхүүгийн кадастр.

87.2.Нөөцийн кадастрт газрын нэгдмэл санг газар ашиглалтын зориулалт, бүрхэвч, төлөв байдал, чанар, чадавхаар нь зураглаж бүртгэх үйл ажиллагаа хамаарна.

87.3.Эрхийн кадастрт нэгж талбарт суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн харилцаа, эрхийн хязгаарлалт, тэдгээрийн хил заагийг зураглаж бүртгэх үйл ажиллагаа хамаарна.

87.4.Санхүүгийн кадастрт газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, үнэлгээ, татвар, төлбөр, тэдгээрийн бүсчлэлийг зураглаж бүртгэх үйл ажиллагаа хамаарна.

87.5.Кадастрын үйл ажиллагаа, түүнийг эрхлэхтэй холбоотой харилцааг Кадастрын тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРТ ХЯНАЛТ ТАВИХ

88 дугаар зүйл.Газрын төлөв байдал, чанарт хяналт тавих

88.1.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн төлөв байдал, чанарт төрөөс хяналт тавьж, түүний үр дүнг үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

88.2.Газрын төлөв байдал, чанарт тавих хяналтыг дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

- 88.2.1.газрын мониторингийн;
- 88.2.2.газрын хянан баталгааны.

88.3.Монгол Улсын иргэний өмчлөл, иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулж буй газарт газрын хянан баталгааг, бусад газарт газрын мониторингийг хэрэгжүүлнэ.

88.4.Газрын мониторинг болон хянан баталгааг дараах ерөнхий үзүүлэлтээр хийнэ:

- 88.4.1.газрын гадаргын төрх байдал;
- 88.4.2.ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургац, бүрхэвч;
- 88.4.3.хөрсний үржил шимт үе давхаргын зузаан;
- 88.4.4.хөрсний ялзмагийн агууламж;
- 88.4.5.хөрсний бохирдол.

88.5.Энэ хуулийн 88.4-т заасан үзүүлэлт дээр тухайн газар ашиглалтын байдал, онцлогийг харгалзан нэмж хэрэглэх үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгаль орчны болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран батална.

88.6.Газрын мониторинг болон хянан баталгаа хийх журмыг Засгийн газар батална.

88.7.Газрын мониторинг болон хянан баталгааны өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах асуудлыг энэ хуулийн 27.2.6-д заасан системээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус гүйцэтгэнэ.

88.8.Газрын мониторинг болон хянан баталгааг гүйцэтгэхдээ зайнаас тандан судлах болон газар дээр нь хэмжилт, судалгаа, шинжилгээ хийх ажилбарыг хослуулан ашиглана.

88.9.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын мониторинг, хянан баталгааны үзүүлэлтүүдийг тодорхойлох хяналтын лабораторитой байна.

89 дүгээр зүйл. Газрын мониторинг

89.1.Газрын мониторингийг байгаль, газар зүй, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан байнгын ажиглалт, судалгаа хийх талбар, цэгийг сонгож, сүлжээг байгуулах замаар гүйцэтгэнэ.

89.2.Газрын мониторингийн сүлжээний цэг нь нэгдүгээр, хоёрдугаар гэсэн зэрэглэлтэй байна.

89.3.Тухайн нутаг дэвсгэрийг бүрэн төлөөлж чадахуйц, тогтвортой, байнгын ажиллагаатай цэгийг нэгдүгээр зэрэглэлд хамруулах бөгөөд цэгийн тоо, байршил, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийх хуваарийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

89.4.Байгаль, цаг уурын өөрчлөлт, газар ашиглалтын байдлыг харгалзсан хөдөлгөөнт цэгийг хоёрдугаар зэрэглэлд хамруулах бөгөөд цэгийн тоо, байршил, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийх хуваарийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

89.5.Монгол Улсын иргэний өмчлөл, иргэн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглаж буй газрын хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлогдсон цэгийн мэдээллийг газрын мониторинг хийхэд нэмэлтээр ашиглаж болно.

89.6.Газрын мониторингийн нэгдүгээр зэрэглэлийн цэг дээр хэмжилт, судалгаа, шинжилгээний ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газар зохион байгуулалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр, хоёрдугаар зэрэглэлийн цэг дээр хэмжилт, судалгаа, шинжилгээний ажлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газар зохион байгуулалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр тус тус хариуцан гүйцэтгүүлнэ.

89.7.Энэ хуулийн 88.5, 88.6-д заасан журам, аргачлалын дагуу 89.6-д заасан хэмжилт, судалгаа, шинжилгээний үр дүнгээр газрын мониторингийг хийж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгана.

89.8.Аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд туссан газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлж ажиллана.

90 дүгээр зүйл.Газрын хянан баталгаа

90.1.Хүн, хуулийн этгээдэд анх удаа газар өмчлөх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр газрыг ашиглуулахдаа газрын хянан баталгааны дүгнэлтийг газрын мониторингийн үр дүнг ашиглан сумын газар зохион байгуулагч, дүүргийн хэлтэс газрын мэдээллийн системээр үнэгүй баталгаажуулна.

90.2.Энэ хуулийн 40.1, 47.1.-т заасан газар өмчлөх эрх, газрын хязгаарлагдмал эрхтэй Монгол улсын иргэнээс бусад газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглагч нь газрын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр дараах тохиолдолд хийлгүүлнэ.

90.2.1.анхны хянан баталгааны дүгнэлтийг хүлээн авснаас хойш 5 жил тутамд;

90.2.2.газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр газрыг ашиглах хугацаа дуусгавар болоход;

90.2.3.газрын хязгаарлагдмал эрх болон газрыг ашиглах гэрээний хугацааг сунгахад.

90.3.Газрын хянан баталгаа нь хүн, хуулийн этгээдэд олгосон газрын төлөв байдал, чанарыг баталгаажуулах, газарт учруулсан хохирлыг тооцох, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулах шийдвэрийг хүчингүй болгох, хугацааг сунгах үндэслэл болно.

90.4.Газрын хянан баталгааг газар зохион байгуулалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

90.5.Хүн, хуулийн этгээд бусдад газраа түрээслэх, ашиглуулахдаа газрын хянан баталгааг өөрийн зардлаар гүйцэтгүүлж болно.

90.6.Хүн, хуулийн этгээд төрөөс шилжүүлэн авсан газартаа газрын хянан баталгааг өөрийн зардлаар гүйцэтгүүлж болно.

АРАВДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫГ ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

91 дүгээр зүйл.Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага

91.1.Газар түүний нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, газрын доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг дээшлүүлэх зорилгоор газрыг зүй зохистой тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

91.2.Газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд болон газрыг гэрээгээр ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараах нийтлэг шаардлагыг биелүүлнэ:

91.2.1.газрын төлөв байдал, чанарыг хадгалах, сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн зардлаар хэрэгжүүлэх;

91.2.2.газрын үржил шим буурах, ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал, хими, биологийн хортой бодисоор бохирдох, хордохоос урьдчилан сэргийлэх;

91.2.3.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос олборлох, тээвэрлэх, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, судалгаа шинжилгээний ажил хийх болон бусад зориулалтаар ухаж ашигласнаас элэгдэж, эвдэрсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулах;

91.2.4.газар, түүний баялаг, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглахдаа хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

91.2.5.өвөрмөц экосистем, ой, усны сан бүхий газар, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгал зүйл бүхий газрыг хамгаалах.

91.3.Энэ хуулийн 91.2-д заасан шаардлагын хэрэгжилтийг холбогдох төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан зохион байгуулж, хяналт тавина.

92 дугаар зүйл.Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага

92.1.Хүн, хуулийн этгээд нь байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулахыг хориглоно.

92.2.Үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын доор хадгалах, булах ажлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон байршилд эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ.

92.3.Энэ хуулийн 92.2-т заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны мэргэжлийн хяналтын байгууллага, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчид мэдэгдэж, уг газрын хил заагийг тэмдэгжүүлж, байнгын харуул ажиллуулах, сэрэмжлүүлэх дохио тэмдэгтүүдийг байрлуулах ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

93 дугаар зүйл.Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах

93.1.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах зориулалтаар газар ашиглуулах асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

93.2.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайхыг хориглох бүсийг тогтоох үндэслэл болно.

93.3.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг дараах газарт олгохыг хориглоно:

93.3.1.улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газар;

93.3.2.гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар;

93.3.3.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар;

93.3.4.тариалангийн газар.

93.4.Ашигт, малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглагч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай болон түүний орчмын газарт үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчид тайлагнана.

93.5.Энэ хуулийн 93.4-т заасан газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний гүйцэтгэлд аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч хяналт тавина.

94 дүгээр зүйл.Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах

94.1.Бэлчээрийн газрыг ашиглах, хамгаалах асуудлыг энэ хуулийн 29.1-д заасан газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний баримт бичигт үе шаттайгаар төлөвлөж, хэрэгжүүлнэ.

94.2.Бэлчээрийн газрыг дараах хуваарьтайгаар ашиглана:

94.2.1.улирлын бэлчээр (өвөл, хавар, зун, намрын);

94.2.2.отрын нөөц бэлчээр;

94.2.3.эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр;

94.2.4.дамжин өнгөрөх бэлчээр;

94.2.5.байгалийн тогтоцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир, мараа, уст цэг бүхий бэлчээр.

94.3.Энэ хуулийн 94.2-т заасан бэлчээрийн газрын хуваарийг аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр тогтооно.

94.4.Энэ хуулийн 94.2.2-т заасан бэлчээрийг гэрээгээр ашиглуулна.

94.5.Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувь нь отрын нөөц бэлчээр байна.

94.6.Отрын нөөц бэлчээрт дараах бэлчээр хамаарна:

94.6.1.аймаг дундын;

94.6.2.сум дундын;

94.6.3.сумын.

94.7.Отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг дараах этгээд тогтооно:

94.7.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил заагийг холбогдох аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар;

94.7.2.сум дундын отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг холбогдох сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

94.7.3.сумын отрын нөөц бэлчээрийн газрын хил заагийг холбогдох багийн иргэдийн Нийтийн Хурал, сумын Засаг даргын санал, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

94.8.Отрын нөөц бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах, мал оруулах, малаас чөлөөлөх асуудлыг бэлчээрийн газрын төлөв байдал, чанар, даацад тохируулан дараах этгээд шийдвэрлэнэ:

94.8.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрт холбогдох аймгуудын Засаг дарга нарын саналыг үндэслэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

94.8.2.сум дундын отрын нөөц бэлчээрт холбогдох сумдын Засаг дарга нарын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга;

94.8.3.сумын отрын нөөц бэлчээрт холбогдох багийн Засаг дарга нарын саналыг үндэслэн сумын Засаг дарга.

94.9.Отрын нөөц бэлчээрийн газрыг зургаан сар хүртэлх хугацаатайгаар малчин иргэнд гэрээгээр ашиглуулна.

94.10.Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил заагийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байршилтай уялдуулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар тогтооно.

94.11.Орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг мал тууврын замын чиглэлтэй уялдуулж, харьяалах сум, дүүргийн Засаг

даргын санал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

94.12.Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.

94.13.Ойн сан бүхий газрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг энэ хуулийн 94.15

-д заасан нийтлэг журмаар зохицуулна.

94.14.Сумын Засаг дарга бэлчээрийн газрыг хамгаалах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

94.14.1.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгасан бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, отор нүүдэл хийх сар, улирлын хуваарийг мөрдүүлэх;

94.14.2.газрыг цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрт мод, бут сөөг, олон наст ургамал тарих, бууцаар бордох, хаших зэрэг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах ажлыг зохион байгуулах;

94.14.3.бэлчээр, хадлангийн газар болон байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх, биологийн төрөл, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор зам, даваа засах, гүүр, инженерийн хийцтэй худаг, хөв цөөрөм барьж байгуулах, булаг шандны эхийг хамгаалах зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.

94.15.Энэ хуулийн 94.2-т заасан бэлчээрийн газрыг ашиглах, хамгаалах асуудлыг Засгийн газраас баталсан бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах нийтлэг журмаар зохицуулна.

94.16.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарсан тохиолдолд тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хамтран шийдвэрлэнэ.

94.17.Энэ хуулийн 94.16-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэнэ.

94.18.Бэлчээрийн газрыг ашиглахтай холбоотой маргааныг энэ хуульд заасан газрын маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ.

94.19.Бэлчээрийн газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

94.19.1.зун, намрын бэлчээр, байгалийн тогтоцоор бий болсон хужир, мараа, уст цэг бүхий бэлчээр болон аймаг дундын отрын бэлчээрийн газарт өвөлжөө, хаваржааны барилга байгууламж, гэр, сууц барих зориулалтаар газрын хязгаарлагдмал эрх олгох;

94.19.2.авто зам гаргах, хөрсийг эвдэх, бохирдуулах, бусад байдлаар газрын төлөв байдал, чанарыг доройтуулах;

94.19.3.цөл, цөлөрхөг хээрийн бүсэд, эсхүл хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх эрсдэл бүхий бэлчээрт ургамал түүх, хадлан бэлтгэх.

94.20.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн шугамаас хоёр тийш таван километр хүртэлх газар нутагт хилийн цэсийн бүс нутагт хамаарах бөгөөд тухайн бүс нутагт зөвхөн мал бэлчээх, худаг, уст цэг ашиглах эрх нь тухайн хилийн цэсээр хязгаарлагдахгүй.

95 дугаар зүйл.Бэлчээрийн газрыг хамгаалах талаар газар ашиглагчийн үүрэг

95.1.Бэлчээрийн газар ашиглагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

95.1.1.бэлчээрийн даацад малын тоог нийцүүлэх, малын тоог бууруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд үе шаттай шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

95.2.2.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, сумын Засаг даргын шийдвэрийн дагуу бэлчээрийн газрыг сэлгэх, өнжөөх, улирлаар нүүх хуваарийг мөрдөж, тогтоосон хугацаанд мал оруулах, гаргах;

95.2.3.өвөлжөө, хаваржааны бэлчээрт зун, намрын улиралд мал оруулахгүй хамгаалах, бэлчээрийг доройтуулахгүй байх;

95.2.4.дамжин өнгөрөх бэлчээр, байгалийн тогтоцоор бий болсон хужир мараа, уст цэг бүхий бэлчээр, зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулж өвөлжөө, хаваржааны барилга байгууламж, хашаа саравч барихгүй, суваг, шуудуу ухахгүй байх;

95.2.5.хөрш болон саахалт малчид, малчин өрх, мал бүхий этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

95.2.6.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бэлчээрийн газарт учруулсан хохирлыг нөхөн төлөх;

95.2.7.бэлчээрийн газрын хөрсийг эвдэхгүй, хөрс, усыг бохирдуулахгүй, хог хаягдал хаяхгүй байх;

95.2.8.бэлчээрт дур мэдэн авто зам гаргахгүй байх;

95.2.9.бэлчээрт эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр өвөлжөө, хаваржааны барилга байгууламж, хашаа саравч барихгүй байх.

96 дугаар зүйл.Бэлчээрийн газарт учруулсан хохирлыг нөхөн төлөх

96.1.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбоотойгоор бэлчээр, хадлангийн талбай болон бэлчээр ашиглагчид хохирол, хор уршиг учруулбал тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хор уршигийг арилгах, хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

96.2.Газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалж бэлчээр, хадлангийн талбайд учруулсан хохирлыг тухайн үйлдвэрлэл эрхлэгч нөхөн төлнө.

96.3.Энэ хуулийн 94.15-д заасан бэлчээрийн газрыг ашиглах, хамгаалах нийтлэг журмыг зөрчсөний улмаас учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

96.4.Бэлчээрийн газрыг дайран өнгөрөхдөө учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

97 дугаар зүйл.Хадлангийн газрыг зохистой ашиглах, хамгаалах

97.1.Хадлангийн газрыг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тогтоож, газрын нэгдмэл санд бүртгэнэ.

97.2.Газрын нэгдмэл санд бүртгэлтэй хадлангийн газрыг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн дуудлага худалдааны ялагчид аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын узуфрукт эрх олгоно.

97.3.Сумын газар зохион байгуулагч сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн бэлчээрийн газрын тодорхой ургацтай хэсгийг хадлан хадах зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд тухайн жилдээ гэрээгээр ашиглуулж болно.

97.4.Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуусах хүртэлх хугацаанд хадлангийн газарт мал бэлчээхийг хориглоно.

97.5.Энэ хуулийн 97.1-д заасан хадлангийн газрыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

98 дугаар зүйл.Тариалангийн газрыг зохистой ашиглах, хамгаалах

98.1.Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх асуудлыг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

98.2.Тариалангийн газрын захаас гадагш 500 метр хүртэлх зайд мал бэлчээх, оторлох болон өвөлжөө, хаваржаа байхыг хориглоно. Хамгаалалтын зурвасын хил заагийг сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөгөөр тогтооно.

98.3.Энэ хуулийн 98.1-д заасны дагуу тариалангийн газарт шилжүүлэхдээ тухайн газар болон энэ хуулийн 98.2-т заасан хамгаалалтын зурваст хамаарч буй өвөлжөө, хаваржааны барилга байгууламж барих газрын хязгаарлагдмал эрхтэй иргэний газрыг нөхөх олговортойгоор чөлөөлсөн байна.

98.4.Тариалангийн зориулалтаар газрын узуфрукт эрхтэй этгээд нь хөрс хамгаалах технологи, усжуулалтын арга хэмжээг нэвтрүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах үүрэгтэй.

98.5.Тариалангийн зориулалтаар газрын узуфрукт эрхтэй этгээд нь хөрсний үржил шимийг бууруулсан, хордуулж бохирдуулсан, бусад хэлбэрээр доройтуулсан нь газрын хянан баталгааны дүгнэлтээр тогтоогдсон бол энэ хуулийн 98.4-т заасан арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хийнэ.

99 дүгээр зүйл.Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах

99.1.Хот, тосгон, бусад суурины газарт иргэнд газар өмчлүүлэх, хүн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрх олгох, гэрээгээр ашиглуулах болон бусад газар зохион байгуулалтын арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар ашиглалтын бүсчлэлийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

99.2. Хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, авто болон явган хүний зам, хүн, хуулийн этгээдэд олгогдоогүй авто зогсоол, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, хог хаягдлын цэг, оршуулгын газар зэрэг газар хамаарна.

99.3.Тухайн нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газрыг хамгаалах, тохижуулах, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах ажлыг тухайн шатны Засаг дарга хариуцна.

99.4.Энэ хуулийн 10.1.5-т заасан газарт хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар доторх цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, түүний цэвэршүүлэх талбай, үерийн суваг, шуудуу, далан бүхий газар, тээвэр, холбооны зориулалтаар олгогдсон газар хамаарна. Эдгээр газарт хамгаалалтын бүс, зурвас газар тогтоох, түүний ашиглалт, хамгаалалттай холбогдсон харилцааг энэ хуулийн 100, 102 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

99.5.Монгол Улсын иргэний өмчлөлийн газар, хүн, хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхтэй болон гэрээгээр ашиглаж буй газрын зохих хувь нь ногоон байгууламжтай байна. Ногоон байгууламжийн эзлэх хувийг энэ хуулийн 15.6-д заасан ашиглалтын бүсчлэлийн дүрэм, дэглэмээр тогтооно.

99.6.Энэ хуулийн 99.2-т заасан нийтийн эдэлбэрт хамаарах газрыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

99.7.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрыг шинээр тогтоох, өөрчлөхийн өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

100 дугаар зүйл.Зам, шугам сүлжээний газрыг зохистой ашиглах, хамгаалах

100.1.Зам, шугам сүлжээний зориулалтаар газрын хязгаарлагдмал эрх олгох болон газрыг гэрээгээр ашиглуулахдаа газрын байршил, трассын зураг төсөл, газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэнэ.

100.2.Авто зам нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалт бүхий зурвас газартай байна.

100.3.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын гаднах олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөн 100 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 50 метр/, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөн 60 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 30 метр/ байна.

100.4.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын доторх авто замын зурвас газрын өргөнийг энэ хуулийн 100.3-т заасан хэмжээнд багтаан аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

100.5.Авто замын зурвас газарт авто зам, замын байгууламжийн ашиглалттай холбоотой үйл ажиллагаа болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах технологийн үйл ажиллагаа явуулах, инженерийн шугам сүлжээ, тэдгээрийн дэд бүтэц байгуулахаас бусад зорилгоор газар ашиглуулахыг хориглоно.

100.6.Төмөр замын шугамын дагуу технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий төмөр замын зурвас газартай байна.

100.7.Төмөр замын зурвас газрын болон аюулгүйн бүсийн дэглэм, хэмжээг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

100.8.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газрын хязгаарлагдмал эрх олгох, газрыг гэрээгээр ашиглуулахдаа эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан шийдвэрлэнэ.

100.9.Хамгаалалтын байгууламжтай хурдны авто зам, төмөр зам, дамжуулах хоолой барьж байгуулахдаа хүн, мал, зэрлэг амьтны гарцыг заавал гаргана.

100.10.Харилцаа холбооны шугам сүлжээ, тэдгээрийн барилга байгууламж нь хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвас газар нь дараах хэмжээтэй байна:

100.10.1.агаарын баганат шугамаас хоёр тийш 5 метр;

100.10.2.кабелийн шугамаас хоёр тийш 1 метр.

100.11.Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг энэ хуулийн 102.5-д заасны дагуу тогтооно.

100.12.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

100.13.Эрчим хүчний шугам сүлжээ, тэдгээрийн дэд бүтэц нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасыг Засгийн газрын баталсан эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэмд заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

100.14.Зам, шугам сүлжээний зориулалтаар газрын хязгаарлагдмал эрх, газрыг гэрээгээр ашиглуулахдаа зураг төсөлд заасан газрын хэмжээгээр газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж тухайн шугам сүлжээний газар болон хамгаалалтын зурвасыг газрын мэдээллийн системд бүртгэнэ.

100.15.Зам, шугам сүлжээний зориулалтаар газрын хязгаарлагдмал эрх, газрыг гэрээгээр ашиглахдаа палеонтологи, археологи, угсаатны зүйн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

100.16.Эрчим хүч, харилцаа холбоо, ус дамжуулах шугам сүлжээний газрын хамгаалалтын зурвасын дотор зам, шугам сүлжээний барилга байгууламж барихаас бусад зориулалтаар газрын хязгаарлагдмал эрх олгох, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

100.17.Зам, шугам сүлжээний хамгаалалтын зурвас газарт засвар үйлчилгээ хийх болон бусад зорилгоор ажил гүйцэтгэсэн этгээд тухайн хамгаалалтын зурвас газрыг хэвийн байдалд буцаан оруулж, нөхөн сэргээх үүрэг хүлээнэ.

101 дүгээр зүйл. Ойн сан бүхий газрыг зохистой ашиглах, хамгаалах

101.1.Ойн сан бүхий газрын хил заагийг газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлээр тогтоож, энэ хуулийн 27.1-д заасан газрын мэдээллийн системд бүртгэнэ.

101.2.Ойн сан бүхий газар нь хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи, эдийн засгийн ач холбогдлоосоо хамааран дараах бүстэй байна:

101.2.1.хамгаалалтын бүсийн ой;

101.2.2.ашиглалтын бүсийн ой.

101.3.Ойн сан бүхий газрын төлөв байдал, чанарт хохирол, хор уршиг учруулсан гэм буруутай этгээд нь хор уршигийг арилгах, хохирлыг нөхөн төлнө.

101.4.Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, харилцаа холбооны шугам татах, түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

102 дугаар зүйл.Усны сан бүхий газрыг зохистой ашиглах, хамгаалах

102.1.Усны сан бүхий газар нь дараах бүс, мужтай байна.

102.1.1.онцгой хамгаалалтын бүс ;

102.1.2.энгийн хамгаалалтын бүс;

102.1.3.эрүүл ахуйн бүс;

102.1.4.ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн муж.

102.2.Энэ хуулийн 102.1-д заасан бүс, мужийн хил заагийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

102.3.Энэ хуулийн 102.2-т заасны дагуу усны сан бүхий газрын бүс, мужийг дараах хэмжээг баримтлан тогтооно:

102.3.1.усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс;

102.3.2.усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс.

102.4.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн эрүүл ахуй, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг байгаль орчны болон газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

102.5.Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах байдлаар тогтоож, хэрэгжилтийг хангуулна:

102.5.1.хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр /худаг/-ийн эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс доошгүй зайд;

102.5.2.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн энгийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг энэ хуулийн 102.3-т зааснаар;

102.5.3.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг ашиглахдаа хамгаалалтын бүсийг мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 500 метрээс багагүй зайд;

102.5.4.урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсацыг харгалзан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоож, дэглэмийг энэ хуулийн 102.4-д заасны дагуу.

102.6.Улсын болон аймгийн зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээгдлийн муж болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хуримтлуулах талбайг хамруулан тогтоож болно.

102.7.Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш 5 метрт хамгаалалтын зурвас тогтооно.

102.8.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.

102.9.Рашааны эргэн тойрны газарт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг дараах хэмжээгээр тогтооно:

102.9.1.рашааны орд, эх булгийн эргэн тойронд 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүсийг;

102.9.2.хамгаалалтын бүс нь хориглолтын болон хязгаарлалтын бүсээс бүрдэх бөгөөд эрүүл ахуйн бүсийн эргэн тойронд 200 метрээс доошгүй зайд хориглолтын бүсийг;

102.9.3.хязгаарлалтын бүсийг усны мэргэжлийн байгууллага тогтоох.

102.10.Рашааны эрүүл ахуйн бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

102.10.1.рашаан шууд авч ашиглахаас өөр зориулалтаар барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурьлуулах;

102.10.2.хог хаягдал хаях, химийн бодис хадгалах, хэрэглэх.

102.11.Рашааны хориглолтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

102.11.1.рашааныг ашиглах зориулалттай барилга байгууламжийг хаягдал ус цэвэрлэх, зайлуулах байгууламжгүй барих;

102.11.2.газар тариалан эрхлэх, мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх;

102.11.3.хог хаягдал хаях, хадгалах, бохирын цооног байгуулах зэргээр рашааны чанар байдалд сөргөөр нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулахыг.

102.12.Рашааны хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

102.12.1.ус, рашаан ашиглахтай шууд холбоогүй барилга байгууламж барих;

102.12.2.хог хаягдлын болон хаягдал ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис хадгалах, хэрэглэх зэргээр рашааны чанар байдалд сөргөөр нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулахыг.

102.13.Усны сан бүхий газар, энэ хуулийн 102.1-д заасан бүс, мужийн хил заагийг энэ хуулийн 27.1-д заасан газрын мэдээллийн системд бүртгэнэ.

102.14.Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд газар ашиглах асуудлыг энэ хуулийн 102.4-т заасан дэглэмээр зохицуулна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН ХЯНАЛТ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

103 дугаар зүйл. Газрын нэгдмэл санд тавих төрийн хяналт

103.1. Газрын асуудал эрхэлсэн бүх шатны төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга Газрын ерөнхий хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

103.2.Газрын ерөнхий хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

103.3.Төрийн өмчийн газар дээр зохих зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих, эсхүл бусад хэлбэрээр түүнийг хууль бусаар дур мэдэн ашигласан тохиолдолд аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч нэн даруй таслан зогсооно.

103.4.Энэ хуулийн 103.3-т заасан нөхцөл байдал үүссэн бол аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрыг албадан чөлөөлөх шийдвэр гаргаж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.

103.5.Газрыг албадан чөлөөлөхөд цагдаагийн байгууллага дараах үүрэгтэй:

103.5.1.хууль, гэрээнд заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглалтын гэрээ дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газрыг ашигласан бол газрыг албадан чөлөөлөх журмын хэрэгжилтийг хангах;

103.5.2.газар албадан чөлөөлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байгаа албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, санаатайгаар саад учруулсан, эсэргүүцсэн бол Цагдаагийн албаны тухай хуулийн 23.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

104 дүгээр зүйл.Газрын нэгдмэл санд тавих хөндлөнгийн хяналт

104.1.Бүх шатны газрын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод хүртээмжтэй байгаа эсэхэд хөндлөнгөөс тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэх боломжийг бүрдүүлж ажиллана.

105 дугаар зүйл.Газрын харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх

105.1.Газрын харилцаатай холбоотой хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааны талаарх гомдлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ.

105.2.Энэ хуулийн 105.1-д заасан эрх бүхий байгууллага нь хүн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

105.3.Энэ хуулийн 105.2-т заасан хугацаанд эрх бүхий этгээд хариу өгөөгүй, эсхүл хүн, хуулийн этгээд нь аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор газрын маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.

105.4.Хүн, хуулийн этгээд нь энэ хуулийн 105.3-т зааснаас гадна газрын харилцаатай холбоотой дараах маргааны талаарх гомдлоо газрын маргаан таслах зөвлөлд гаргана:

105.4.1.газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх, дундын мэдлийн газрын эрх болон газрыг гэрээгээр ашиглуулахтай холбоотой асуудлаар;

105.4.2.аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйлдэл, эс үйлдлийн талаар;

105.4.3.дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагчийн үйлдэл, эс үйлдлийн талаар;

105.4.4.газрын төлбөр, татварын ногдуулалттай холбоотой асуудлаар;
105.4.5.улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхтэй холбоотой асуудлаар.

105.5.Энэ хуулийн 105.1-105.4-т заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

105.6.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь Маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасан шалтгаанаар маргаан таслах зөвлөл нь хүн, хуулийн этгээдийн гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол гомдол гаргагчид 14 хоногийн дотор буцаана.

106 дугаар зүйл. Маргаан таслах зөвлөл

106.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд хүн, хуулийн этгээдээс газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх, дундын мэдлийн газрын эрх, газрыг гэрээгээр ашиглуулах, газар чөлөөлөхтэй холбоотой гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус газрын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

106.2.Газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд тусгай хэрэгцээний газартай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Маргаан таслах зөвлөл ажиллана.

106.3.Энэ хуулийн 106.1-д заасан маргаан таслах зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох төрийн байгууллагын төлөөлөл болон мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 9 эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

106.4.Энэ хуулийн 106.2-т заасан Маргаан таслах зөвлөлийг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл болон мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 9 эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

106.5.Маргаан таслах зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

106.6.Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

106.7. Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь газар зохион байгуулагч, газрын кадастр, газрын үнэлгээ, геодезийн инженер, эсхүл эрх зүйч, эдийн засагч мэргэжилтэй, мэргэжлээрээ таваас дээш жил ажилласан туршлагатай байна.

107 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх

107.1.Маргаан таслах зөвлөл энэ хуулийн 106.6-д заасан журмын дагуу дүгнэлт гаргана.

107.2.Маргаан таслах зөвлөлийн хуралдаан нь бүх гишүүний гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцогдоно.

107.3.Маргаан таслах зөвлөл маргаанд оролцогч талуудаас нотлох баримт шаардах эрхтэй бөгөөд нотлох баримт ирүүлээгүй бол ирүүлсэн нотлох баримтын хүрээнд гомдлыг хянан дүгнэнэ.

107.4.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

107.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 107.1-д заасан дүгнэлтийг үндэслэн өмнө гаргасан шийдвэрээ хүчингүй болгох, өөрчлөх шийдвэр гаргаж болно.

107.6.Маргаан таслах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг оролцогч талууд хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дүгнэлтийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.

107.7.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, уг дүгнэлтийг маргааны оролцогч талуудад гардуулна.

107.8.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 107.7-д заасан шийдвэр гаргах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

107.9.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн үндэслэлийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн шийдвэрийг гомдол гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, хувийн мэдээллийг таних боломжгүйгээр цахим хуудсаар мэдээлнэ.

107.10.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, газрын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны бүх шатны байгууллагад хүргүүлэх эрхтэй.

108 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх

108.1.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан, бохирдуулсан, хор уршиг учруулсан хүн, хуулийн этгээд нь Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр нөхөн сэргээх үүрэгтэй. Хэрэв нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээд бүрэн хариуцна.

108.2.Газарт учруулсан хохирлын хэмжээг тооцох, нөхөх төлбөр төлүүлэх журмыг газар, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

109 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

109.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

109.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

110 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

110.1.Энэ хуулийг 2022 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 6 дугаар сарын 07-ны өдөр баталсан Газрын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.

Одоогийн газар эзэмших, ашиглах эрхийг газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрх, сервитут, дундын мэдлийн газрын эрх, газрыг гэрээгээр ашиглах харилцаанд шилжүүлэхтэй холбогдуулан Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 сарын дотор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1.1.Одоогийн газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг газрын мэдээллийн системээр хүлээн авч, шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

1.2.Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авах, хянах, эрх зүйн зөрчлийг арилгах, нэгж талбар бүрээр цаасан болон цахим хувийн хэрэг үүсгэхийг дүүргийн хэлтэс, сумын газар зохион байгуулагч;

1.3.Газрын ерөнхий хуульд нийцүүлэн газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрх, сервитут, дундын мэдлийн газрын эрхийг болон газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргахыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

1.4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дундын мэдээллийн санд байршуулсан хүсэлт, холбогдох материалыг үндэслэн газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрх, сервитут, дундын мэдлийн газрын эрхийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн дугаарыг нэн даруй олгохыг Улсын бүртгэлийн ерөнхий газар;

1.5.Газрыг гэрээгээр ашиглах тухай хүсэлтээ газрын мэдээллийн системээр дамжуулан гаргахыг газар эзэмших эрхтэй төрийн болон орон нутгийн өмчит байгууллага;

1.6.Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон Чөлөөт бүсэд газар ашиглагч иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах гэрээг газрын мэдээллийн системд бүртгэхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Чөлөөт бүсийн захирагч.

2 дугаар зүйл.

Газрыг гэрээгээр ашиглах тухай хүсэлтээ Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор газрын мэдээллийн системээр ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчид гаргаж, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлнэ.

3 дугаар зүйл.

Газрын ерөнхий хуульд заасан хамгаалалтын, онцгой, хязгаарлалтын, аюулгүйн, эрүүл ахуйн бүс, зурвас газрын хил заагийг тогтоох, зохих журмын дагуу шийдвэрлүүлж газрын мэдээллийн системд бүртгүүлэхийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд зохион байгуулна.

4 дүгээр зүйл.

Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан зохицуулалтыг хугацаанд нь шийдвэрлүүлээгүй газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг одоогийн газар эзэмших, ашиглах эрхээсээ татгалзсанд тооцно.

5 дугаар зүйл.

Монгол Улсын иргэнд газрын узуфрукт эрх болон барилга байгууламж барих газрын эрхээр нэг удаа, үнэгүй олгохтой холбогдсон Газрын ерөнхий хуулийн 80.1 дэх хэсэг одоогийн газар эзэмшигч нарт хамаарахгүй.

6 дугаар зүйл.

Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, газар ашиглалтын дүрмийг батлуулж мөрдүүлэх ажлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

7 дугаар зүйл.

Энэ хуулийг Газрын ерөнхий хууль хүчинтэй болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг:

“16.2.олон улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын хэмжээг Газрын ерөнхий хуулийн 100.3-д заасны дагуу тогтооно.”

2/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6.Авто замын зурвас газарт Газрын ерөнхий хуулийн 100.5-д зааснаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглох бөгөөд уг үйл ажиллагааг явуулах зөвшөөрлийг автозамын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Автозамын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Газрын хууль” гэснийг “Газрын ерөнхий хууль” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль буюу гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн” гэснийг “Монгол Улсын иргэн, хуулийн этгээд хууль болон гэрээнд заасны дагуу Газрын ерөнхий хуулийн 38.1, 47.1-т заасан үндэслэлээр газар өмчлөх болон болон газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэн авсан газартаа” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дугаар зүйлийн 4.1.44 дэх заалт:

“4.1.44. “ногоон барилга” гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай, хур тундасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг”

2/33 дугаар зүйлийн 33.1.22¹ дэх заалт:

“33.1.22¹. Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам батлах”

3/33 дугаар зүйлийн 33.1.22² дахь заалт:

“33.1.22². Ногоон барилгыг үнэлэх, гэрчилгээжүүлэх журам, заавар батлах”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “далан хаалт” гэсний дараа “зам гүүр” гэж, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтын “түүхий тос дамжуулах хоолой” гэсний дараа “металлург, хими болон хүнд үйлдвэр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтын “34.1.4” гэсний дараа “34.1.5” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Барилгын тухай хуулийн 10.1.5 дахь заалтад хамаарах ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно.”

2/33 дугаар зүйлийн 33.1.7 дахь хэсэг:

“33.1.7.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологи, ногоон хөгжлийн баримт бичгийг боловсруулж батлах”;

2/34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь хэсэг:

“34.1.5.барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологи, ногоон хөгжлийн баримт бичгийг хэрэгжүүлэх”;

4 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “өмчлөл, эзэмшил, ашиглалтад” гэснийг “өмчилсөн болон газрын хязгаарлагдмал эрхээр, эсхүл газар гэрээгээр ашиглаж” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийн “тухайн газрын эзэмшигч буюу өмчлөгчийг” гэснийг “газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд болон газар гэрээгээр ашиглагчийг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийн “барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.9.4 дэх заалтын “10.1.4” гэснийг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтын “34.1.15” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1.15 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалтын “газар эзэмших зөвшөөрөл” гэснийг “газар ашиглуулах гэрээ” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалтын “газар эзэмших зөвшөөрөлтэй” гэснийг “газар ашиглах гэрээтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “эзэмшил газрынхаа хилийн” гэснийг “өмчилсөн газар, газрын хязгаардагдмал эрх болон газар ашиглуулах гэрээгээр”, 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “өмчлөх, эзэмших, ашиглах талаарх бусдын” гэснийг “газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд болон газар ашиглуулах гэрээгээр ашиглагчийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 заалтын “газар зүйн” гэсний ард “болон хаягийн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“27.10.Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүй бүсэд газрын хязгаарлагдмал эрх олгох, газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын ерөнхий хуулийн 100.8 дахь хэсэгт заасныг баримталж шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.5.2.сэргээгдэх эрчим хүчний эрх үүсвэрийг байршуулах зориулалтаар газрыг газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглах асуудлыг Газрын ерөнхий хуулийн 36.5.1-д заасны дагуу аймаг нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлүүлэх.”

2 дугаар зүйл.Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “газрыг эзэмших эрхийн гэрчилгээний” гэснийг “газрын хязгаарлагдмал эрх, эсхүл газар ашиглуулах ашиглуулах гэрээ байгуулах шийдвэр, гэрээний” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“33.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга эрчим хүчний шугам сүлжээний хамгаалтын зурвасыг Газрын ерөнхий хуулийн 100.13-т заасны дагуу тогтоож, газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгуулна.”

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн “дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа” гэснийг “дагуух” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “газрын” гэсний ард “хэсэгчилсэн гэж, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хэлбэрээр” гэсний ард “улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын журмаар,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай

1/ 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“Монгол Улсын иргэн, хуулийн этгээд улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах хүсэлтээ газрын биржид гаргана.”

2/38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд Газрын ерөнхий хуулийн 50.1.3, 50.1.5-д заасан эрхийг эдэлж, мөн зүйлийн 50.2.2-50.2.6, 50.2.9-50.2.12-д үүргийг хүлээнэ.”

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Газрын тухай хууль” гэснийг “Газрын ерөнхий хууль” гэж, 30 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг” гэснийг “тоог зохих журмын дагуу тогтоох” гэж, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5 жилээс илүүгүй” гэснийг “5 жил” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж байгууллагад” гэснийг “хуулийн этгээдэд” гэж, 40 дүгээр зүйлийн гарчиг, 40 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “эрх” гэснийг “гэрээ” гэж, 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд” гэснийг “хууль болон газар ашиглах гэрээнд заасан үндэслэлээр ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйл, 38 дугаар зүйлийн 2 хэсэг, 40 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай;

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9, 19.10 дахь хэсэг нэмсүгэй.

“19.9.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрыг гэрээгээр ашиглах хүсэлтээ 30 хоногт багтаан аймаг нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана;

19.10.Энэ хуулийн 19.9-т заасан хүсэлтийг Газрын ерөнхий хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулсугай.

1/42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрх эзэмшигч, гэрээгээр газар ашиглагч нарын хооронд тухайн газарт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, ашиглах талаар гарсан маргааныг Иргэний хууль болон Газрын ерөнхий хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.”

2/20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт:

“20.1.7.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглагчийн зөвшөөрсний дагуу түүний газраар нэвтрэх, дайран өнгөрөх сервитут тогтоолгох.”

2 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Газрын тухай” гэснийг “Газрын ерөнхий” гэж, 20 дугаар зүйлийн “20.2 дахь хэсгийн “Газар өмчлөгч, эзэмшигч” гэснийг “Газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрх эзэмшигч, гэрээгээр газар ашиглагч” гэж, 42 дугаар зүйлийн гарчгийн “эзэмшигч,” гэснийг “газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглагч” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 2/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “Газрын тухай хуулийн 3.1.6-д” гэснийг “Газрын ерөнхий хуулийн 4.1.8-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалтын “газар эзэмшиж, ашиглаж байгаа” гэснийг “газрыг газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглуулах гэрээгээр ашиглаж” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “ашиглаж, эзэмшиж байгаа болон өмчийн” гэснийг “өмчлөсөн, газрын хязгаарлагдмал эрх, газар ашиглуулах гэрээгээр ашиглаж байгаа” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн” гэснийг “газрын хязгаарлагдмал эрхтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн” гэснийг “барилга байгуудамж барих газрын эрхийн” гэж, 8.1.5 дахь заалтын “узуфруктын” гэснийг “узуфрукт эрхийн” гэж, 8.1.9 дэх заалтын “газар эзэмших, ашиглах эрхийн” гэснийг “Дундын мэдлийн газрын эрх” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.10 дахь хэсэг нэмсүгэй.

“11.10. Иргэн өмчлөлийн газраа Газрын ерөнхий хуулийн 42.1.2-т заасны дагуу Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламж барих газрын эрхээр шилжүүлснийг мөн зүйлийн 42.5-т заасан аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрт үндэслэн бүртгэж, шилжүүлнэ

2 дугаар зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “үндэслэн” гэсний ард “дундын мэдлийн газрын эрхээр” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.7 дахь заалтын “өмчлөлийн” гэсний өмнө “газраас бусад” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэг:

“5.9. Газрын ерөнхий хуулийн 42.1-д зааснаар дагуу иргэнд өмчүүлсэн газрыг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгэнэ.”

2/28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг:

“28.1. Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын хэлтэс, сумын газар зохион байгуулагч нь газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд оруулж, цахимаар мэдүүлэх ба мэдүүлгийн үнэн зөвийг хариуцна:

28.1.1. газрын узуфрукт эрх, барилга, байгууламж барих газрын хязгаарлагдмал эрх олгосон шийдвэрийн хуулбар;

28.1.2.газрын узуфрукт эрх, барилга, байгууламж барих газрын эрхийн гэрчилгээний хуулбар;

28.1.3.бусдын газрын эрхэд сервитут тогтоосон шийдвэр, гэрээ;

28.1.4.газрын кадастрын зураг;

28.1.5.газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрхийг бусдад шилжүүлэх гэрээ;

28.1.6.газрыг улсын тусгай хэрэгцээнд нөхөх олговортойгоор солих, эсхүл эргүүлэн авах тухай шийдвэр, гэрээ.

3/28 дугаар зүйлийн 28.5 хэсэг:

“28.5 Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын хэлтэс, сумын газар зохион байгуулагч нь газрын эрхийн гэрчилгээнд энэ хуулийн 28.3-т заасан улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ.”

4 дүгээр зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль” гэснийг “Газрын ерөнхий хууль, Кадастрын тухай хууль” гэж, 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “эзэмших, ашиглах” гэснийг “энэ хуулийн 28-д заасан” гэж, 28 дугаар зүйлийн гарчгийн, 28 дугаар зүйлийн 28.2, 28.3 дахь хэсгийн “газар эзэмших, ашиглах” гэснийг “газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрх” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “эзэмших, ашиглах” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

“4.2.Хууль тогтоомжид заасан журмын дагуу газрыг хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн газартаа хувийн хөрөнгө оруулалтаар зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно.”

Тайлбар: “Ой модыг өмчилж болно” гэдэгт тухай ой модыг тарьж ургуулсан газар хамааргүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.8 дахь хэсэг нэмсүгэй:

“22.8.Энэ хуулийн 22.5-т заасны дагуу газар олгосон шийдвэрт дурдсан мэдээллийг Газрын ерөнхий хуулийн 24.2.4-т заасан кадастрын мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулна.”

2 дугаар зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг:

“22.2.Чөлөөт бүсэд газрыг хүн, хуулийн этгээдэд Газрын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу ашиглуулна.;

2/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Чөлөөт бүсэд хүн, хуулийн этгээдэд ашиглуулах газрын суурь үнэлгээг Засгийн газар, газрын төлбөрийн хэмжээг Газрын төлбөрийн тухай хуулиар тогтооно;”

3/22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг:

22.5.Чөлөөт бүсийн захирагч нь дуудлага худалдааны ялагчаар дуудлага худалдаанд амалсан үнийг, төсөл сонгон шалгаруулалтын ялагчаар хууль тогтоомжид заасан журмын дагуу итгэлцүүрээр тогтоосон дуудлага худалдааны анхны үнэтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөрийг төлүүлсний дараа Газрын ерөнхий хуулийн 75.1-т заасны дагуу газрын ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна;

4/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Чөлөөт бүсэд Газрын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу газар ашиглаж байгаа хүн хуулийн этгээдэд газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна;”

5/8 дугаар зүйлийн 8.7.7 дахь заалт:

“8.7.7.чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт хүн, хуулийн этгээдэд энэ хуулийн 22.5-д заасныг үндэслэн газар ашиглуулах шийдвэр гаргах;”

3 дугаар зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “аж ахуйн нэгжийн газар эзэмших ашиглах эрхийг” гэснийг “бол хүн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг цуцалж, газар ашиглуулах шийдвэрийг хүчингүй болгоно.” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, 22.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“28 дугаар зүйл. Зурвас газар

28.1. Харилцаа холбооны шугам сүлжээ, тэдгээрийн барилга байгууламжийн хамгаалалтын зурвас газрын хэмээг Газрын ерөнхий хуулийн 100.10-т зааснаар тогтооно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулсугай.

1/12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт:

“12.1.1. Газрын ерөнхий хуулийн 72.1.3, 72.1.4-т заасан хугацаагаар газар ашиглуулах;”

2 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 2.2 дахь хэсгийн “Газрын тухай” гэснийг “Газрын ерөнхий хууль” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Газрын хууль” гэснийг “Газрын ерөнхий хууль” гэж, 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтын “иргэн, аж ахуйн нэгж байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд” гэснийг “хүн, хуулийн этгээд өмчлөлийн болон газрын хязгаарлагдмал эрх, эсхүл гэрээгээр ашиглаж буй газрынхаа нийт талбайн 10 хувиас доошгүй хувьд” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “тариалангийн газар эзэмшигч, ашиглагч” гэснийг “газрыг узуфрукт эрхтэй этгээд тариалангийн газрынхаа” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “эзэмшигч, ашиглагч иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “болон газрын узуфрукт эрх, барилга байгууламж барих газрын эрх, гэрээгээр ашиглагч хүн, хуулийн этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “газар эзэмших” гэснийг газрын хязгаарлагдмал” гэж, мөн зүйлийн 53.3 дахь хэсгийн “ашиглах, эзэмших эрхийн бичгийн” гэснийг “эсхүл газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээний” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “бүс” гэсний дараа “Газрын ерөнхий хуульд заасны дагуу” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

1/22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг:

“22.2. Усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийг Газрын ерөнхий хуулийн 102.3.1-т заасны дагуу тогтооно.”

2/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3. Усан сан бүхий газрын эрүүл ахуйн болон энгийн бүсийг Газрын ерөнхий хуулийн 102.3.2-т заасны дагуу тогтооно.”

3/ 22 дугаар зүйлийг 22.5 дахь хэсэг:

“22.5. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Газрын ерөнхий хуулийн 102.3-т заасны дагуу тогтооно.”

3 дугаар зүйл. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсгийн “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “хүн, хуулийн этгээд” гэж, 22.10 дахь хэсгийн “дараах байдлаар” гэснийг “Газрын ерөнхий хуулийн 102.9-т заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11, 22.12, 22.13 дахь хэсэг, 22.10.1, 22.10.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“26.3.1.улсын хилийн зурваст газар өмчлүүлэх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр ашиглуулахыг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн “тооцсон” гэсний ард “газрын хязгаарлагдмал эрх” гэж нэмэх.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:

30.5. Газрын үнэлгээг Газрын ерөнхий хуулийн 52.1-д заасан эрх шилжүүлэх гэрээний үнэ, эсхүл биржийн арилжааны үнийг;”

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн “4.1.12 дахь заалтыг газар ашиглах, эзэмших эрхийг” гэснийг “газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглах зөвшөөрлийг” гэж, 18 дугаар зүйлийн 18.8, 30 дугаар зүйлийн 30.2, 30.6 дахь хэсгийн “газар эзэмших, ашиглах” гэснийг “газрын хязгаарлагдмал эрх, газар ашиглах гэрээ,” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “Газрын хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтад заасны дагуу сургуульд эзэмшүүлсэн” гэснийг “Газрын ерөнхий хуулийн 67.1.1-т заасны дагуу сургуульд газрыг гэрээгээр ашиглуулж буй” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийг 40.8 дахь хэсгийг “газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд” гэснийг “газрын асуудлыг Газрын ерөнхий хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Газрын тухай хууль” гэснийг “Газрын ерөнхий хууль” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “Газрын тухай хуулийн 12.2-т” гэснийг “хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг нийтийн хэрэгцээг хангахад зориулагдсан газрыг;” гэж, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “эзэмшигчээс” гэснийг “ барилга байгууламж барих эрхтэй этгээдээс”, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “тухай” гэснийг “ерөнхий” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт:

“10.1.5.Газар өмчлөх болон газрын хязгаарлагдмал эрхийг борлуулсан, шилжүүлсэний орлого”.

2/21 дүгээр зүйлийн 21.2.6 дахь заалт:

“21.2.6.Энэ хуулийн 17.2-т заасан газрын суурь үнийг 2 хувиар”.

2 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“17.2.Газар өмчлөх эрх, газрын хязгаарлагдмал эрхийн үнэлгээ тооцох, татвар ногдуулах орлогыг Кадастрын хуульд заасны дагуу тогтоосон газрын суурь үнийн дүнгээр ”

3 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтын “газар эзэмших, ашиглах” гэснийг “газар өмчлөх, газрын хязгаарлагдмал” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “газар эзэмших, ашиглах эрх болон бусад” гэснийг хассугай.

Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсийн “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах байдлаар” гэснийг “Газрын ерөнхий хуулийн 102.5-д заасны дагуу” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.1, 17.4.2, 17.4.3 заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлд дараах агуулгатай 26.13, 26.14 дэх хэсэг тус тус нэмсүгэй.

“26.13. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газрыг гэрээгээр ашиглах хүсэлтээ 30 хоногт багтаан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

“26.14. Энэ хуулийн 26.13-т заасан хүсэлтийг Газрын ерөнхий хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “эрхийг” гэсний ард “улс, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2/21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалт:

“21.1.8. энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөлийн, газрын хязгаарлагдмал эрхтэй болон гэрээгээр ашиглаж буй газарт тухай этгээдийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх эсхүл Газрын ерөнхий хуулийн 63.2.2-т заасан хувийн сервитут тогтоож болно.”

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “Газрын тухай хуульд” гэснийг “Газрын ерөнхий хуулийн 16.2-т” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “эзэмшигч” гэснийг “газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд болон газар гэрээгээр” гэж өөрчилсүгэй.

4 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Мэдэгдэлд заасан хугацаанд хөрсний төлөв байдлыг сайжруулах арга хэмжээ аваагүй бол тариалангийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь Газрын ерөнхий хуулийн 55.1.3-т заасан үндэслэлээр газрын узуфрукт эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох баримтын хамтаар аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

2/27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэг:

“Энэ хуулийн 27.3-т заасан саналыг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрсний төлөв байдлыг дордуулсан иргэн, хуулийн этгээдийн газрын узуфрукт эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, Газрын ерөнхий хуульд заасны дагуу тухайн этгээдэд мэдэгдэнэ.”

2 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь хэсгийн “тухай” гэснийг “ерөнхий” гэж, 26 дугаар зүйлийн 26.9 дэх хэсгийн “Тариалангийн зориулалттай газар эзэмших, ашиглах” гэснийг “газрын узуфрукт” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.5 дахь заалтын “дундын өмчлөлийн” гэсний өмнө, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “бол” гэсний дараа “орон сууцны барилгын доорх болон орчны газраас бусад” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “нийтийн эдэлбэрийн” гэснийг “нийтээр ашиглах газрыг” гэж, 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “орон сууцны байшингийн дэвсгэр болон орчны газрыг эзэмших, ашиглах” гэснийг “дундын мэдлийн газрын” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.8, 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13 дахь заалтын “газрыг” гэсний ард “газар зохион байгуулалт, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/59 дүгээр зүйлийн 59.1.15 дахь заалт:

“59.1.15.газартай холбогдон үүссэн маргааныг Газрын ерөнхий хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлэх;”

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.13, 25 дугаар зүйлийн 25.1.10 дахь заалтуудын “эзэмшлийн” гэснийг “эдэлбэр газрын” гэж, 23 дугаар зүйлийн 23.1.5, 58 дугаар зүйлийн 58.1.13 дахь заалтын “бусдын эзэмшил, ашиглалтад ” гэснийг “хүн, хуулийн этгээдэд газрыг газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглах гэрээгээр” гэж, 59 дүгээр зүйлийн 59.1.18 дахь заалтын “газар ашиглах, эзэмших,” гэснийг “газрыг газрын хязгаарлагдмал эрх, газар ашиглах гэрээгээр болон” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.14, 59.1.16, 60 дугаар зүйлийн 60.1.11 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.11 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.1.11 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт:

21.1.4.Газрын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хуульд нийцүүлэн нийслэл хотын болон нийтийн эдэлбэр газрын ашиглалтын журмыг тогтоох;”

2 дугаар зүйл.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, “эзэмших, ашиглах эрх” гэснийг 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн “газар эзэмшүүлэх, ашиглуулах” гэснийг “газрын хязгаарлагдмал эрх, газрыг гэрээгээр ашиглуулахдаа” гэж, гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫН ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.2.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 15, 16,17, 18, ,19 дэх хэсэг нэмсүгэй:

1/8.1 дүгээр зүйлийн 15 дахь хэсэг:

“15.Газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрх эзэмшигч, газар гэрээгээр ашиглагч хүн, хуулийн этгээд хуульд зааснаас бусад тохиолдолд газрын зориулалтыг өөрчилсөн, газар ашиглалтын бүсчлэлийн дүрэм, дэглэмийг зөрчсөн эсхүл газрыг зориулалтын бусаар ашиглаж орлого олсон бол хууль бусаар олсон орлогыг хураан авч, зөрчлийг арилгуулан хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;”

2/8.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг:

“16.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хураан авч, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;”

3/8.1 дүгээр зүйлийн 17 дахь хэсэг:

“17.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрлийг авснаас хойш 30 хоногийн дотор газрыг гэрээгээр ашиглах хүсэлтээ аймаг, нийслэлийн газрын суудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаагүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

4/8.1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг:

18.Газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд Газрын ерөнхий хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгож, газрыг албадан

чөлөөлж, түүнтэй холбоотой зардлыг нөхөн төлүүлж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

5/8.1 дүгээр зүйлийн 19 дэх хэсэг:

19.Газрын хязгаарлагдмал эрх эзэмшигч, газар гэрээгээр ашиглагч хүн, хуулийн этгээд газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлагыг биелүүлээгүйгээс газрын чанар байдал доройтсон, үр ашиг нь буурсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол газар өмчлөгч болон газрын хязгаарлагдмал эрхтэй этгээдийг эрхийг хүчингүй болгох, газар ажиллах гэрээг цуцлаж, газрыг албадан чөлөөлж, түүнтэй холбоотой зардлыг нөхөн төлүүлж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр дараах хэсэг, заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулсугай.

1/8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Хуульд заасан журмын дагуу газар хязгаарлагдмал эрхийн гэрчилгээгээ барьцаалах, шилжүүлэх тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх, эсхүл газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх, эсхүл барьцаалах журам зөрчсөн бол газрыг хязгаарлагдмал эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газрыг албадан чөлөөлж, газар чөлөөлөхтэй холбоотой зардлыг нөхөн төлүүлж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/8.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Газар ашиглагч нь газар ашиглах гэрээний дагуу ашиглаж байгаа газраа бусдад ашиглуулсан, барьцаалсан бол газар ашиглуулах гэрээг цуцалж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3/8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“8.Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд хадлан авч дуустал мал бэлчээх, эсхүл тариалангийн газарт газрын узуфрукт эрхтэй этгээдийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр мал, амьтан оруулах, бэлчээх, мал бэлчээхийг хориглосон хязгаарлалтыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4/8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

“9. Газрын ерөнхий хуульд заасан газрын нэгдмэл сангийн хөдөө аж ахуйн зориулалттай газрын бэлчээр, хадлан, тариалангийн газрыг, хот, тосгон, бусад суурин газрыг, зам шугам сүлжээний газрыг зохистой ашиглах хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс тухайн газарт хохирол учирсан болох нь газрын хянан баталгааны дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газарт учирсан хохиролыг Газрын ерөнхий хуульд заасны дагуу нөхөн төлүүлж, газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгож, газар ашиглах гэрээг цуцалж хүнийг зургаан зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5/8.1 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх заалт:

“9.1.Тариалангийн газар, хадлангийн талбай, хот, тосгон бусад суурин газар, зам, шугам сүлжээний газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах журам зөрчсөн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

9.4.газрыг бохирдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол газрыг албадан чөлөөлж, газарт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

6/ 8.1 дүгээр зүйлийн 10.3, 10.4 дэх заалт:

“10.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй эсхүл газрыг зохих зөвшөөрөлгүй ашигласан;

10.4.газрын хязгаарлагдмал эрх болон газар ашиглах гэрээ дуусгавар болоход тухайн газрыг газрын хязгаарлагдмал эрхээр эзэмшиж эсхүл газар ашиглах гэрээгээр ашиглаж байсан хүн, хуулийн этгээд хууль буюу гэрээнд заасны дагуу газрыг нөхөн сэргээгээгүй, сайжруулаагүй;”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт” гэснийг “Газрын эрхтэй этгээдийн” гэж, 2 дахь хэсгийг “бусад зориулалтаар бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр” гэснийг “бусдын газарт сервитут тогтоон” гэж, 3 дахь хэсгийн “Газар эзэмшигч, ашиглагч” гэснийг “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын эрх дуусгавар болоход” гэж, 5 дахь хэсгийн “хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган” гэснийг “хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган” гэж, 6 дахь хэсгийн “хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган” гэснийг “хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн

этгээдийг хоёр мянган” гэж, 10.5 дахь хэсгийн “хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган” гэснийг “хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган” гэж, 11 дэх хэсгийн “Газрын тухай” гэснийг “Геодези зураг зүйн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн “эзэмшил, ашиглалтад байгаа газрыг” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын ерөнхий хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо ойлгомжтой болж, газар зохион байгуулалт, газартай холбоотой төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Газрын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Газрын ерөнхий хуультай уялдуулан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Газрын төлбөрийн тухай зэрэг хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. Мөн Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхтэй холбоотой анхдагч хуулийн төслийг боловсруулна.

Түүнчлэн Газрын ерөнхий хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн зарим заалтын хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулна.

--oOo---